



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧ
“БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛ”-ЫН
ҮЕД МӨРДӨЖ АЖИЛЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ,
ЖУРМЫН ХЭРЭГЖИЖ БУЙ БАЙДАЛ**

Улаанбаатар
2021

ННА 67.3
ДАА 340.009
Г-21



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧ “БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛ”-ЫН ҮЕД МӨРДӨЖ АЖИЛЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЖ БҮЙ БАЙДАЛ

Судалгааны багийн ахлагч: Ж.ГАНБААТАР (докторант)

Судлаачид: Б.Доржзаяа, Л.Нямдаваа (докторант)

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн ба тус тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь зөвхөн судлаачдын үзэл бодол, байр суурийг илэрхийлэх болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14240
Утас: 976-73113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9645-7-3

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	4
УДИРТГАЛ.....	5
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	8
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	9
НЭГ: ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧИЙН ОРОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
ХОЁР: “ХӨЛ ХОРИО”, “ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ, “ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМ”-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	20
ГУРАВ: ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ЭРХ, ҮНДЭСЛЭЛ	24
ДӨРӨВ: ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ШИНЭ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ОРНУУДЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА	28
ДҮГНЭЛТ	35
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	37
НОМ ЗҮЙ.....	39
ХАВСРАЛТ 1. САНАЛ АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮН.....	59

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
УОК	УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС
ЦАгтХ	ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ
ЦАР ТАХЛЫН ХУУЛЬ	КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (Ковид - 19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
ЦБ	ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА
ЦАХ	ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ
ИБУИНВУ	ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС

УДИРТГАЛ

Дэлхий дахинд коронавируст (COVID-19) цар тахал дэгдэж хүн амын амь нас, эрүүл мэндэд бодит аюул учирч, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг тогтоон барих, вирусийн халдварыг илрүүлэх, халдварлаж өвчилсөн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчлэх зэрэг хүний эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой нөр их ажил өрнөөд бүтэн жилийн хугацаа өнгөрчээ.

Коронавируст (COVID-19) цар тахал дэлхийн 218 улс, бүс нутагт тархаж, 72,2 сая хүн өвчилснөөс, 1,6 сая хүн нас барж,¹ цар тахлын улмаас бие хүн, гэр бүл, нийгэмд, материаллаг болон материаллаг бус, сэтгэл санааны хийгээд эдийн засгийн асар их хор хохирол учирч, хохирлыг урьдчилан тооцох аргагүй байна.

Олон улсын хэмжээнд коронавирусын эсрэг вакцин бүтээхэд шинжлэх ухаан, технологийн бүх боломжийг дайчилж, вакцины лабораторийн туршилтууд амжилттай болсноор зарим улс орон хүн амаа вакцинжуулах ажлыг өрнүүлж эхэлсэн.

Дэлхийн улс бүр халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, вирусийн халдварын тархалтыг зогсоох, нийтийн эрүүл мэндийг цар тахлын аюулаас хамгаалах үүднээс олон нийтийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, амны хаалт хэрэглэхийг иргэн бүрээс хуулийн хүрээнд шаардах, уриалах, ариутгал халдваргүйжүүлэлтийг хүн ам суурьшиж нягтарсан газар, барилга байгууламжид хийх, ялангуяа коронавирусээр халдварласан, өвчилсөн хүний орчинд хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтоох ариутгал хийх, хавьтагчийг олж тогтоох, шинжилгээ авах, тусгаарлах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг богино болон удаан хугацаагаар хаах зэрэг төрийн албадлагын шинжтэй олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Ялангуяа уг вирусын халдварын тархалтыг зогсооход бүх нийтийн хөдөлгөөнд тавих хязгаарлалтыг ихэнх улс орон өөр

¹ 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар <https://covid19.mohs.mn/>

өөрсдийн нийгэм, эдийн засгийн байдал, улс төр, эрх зүйн тогтолцоо, нийгмийн сэтгэл зүй, соёл иргэншил, төрийн байгууллагын үйл ажиллагааны туршлага зэрэг онцлогтоо тохируулан авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, БНСУ “COVID-19” цар тахал тархахад онц байдал зарлаж, бүх нийтийг хамарсан хөдөлгөөний хязгаарлалт тогтоогоогүй.²

Олон улсын хэмжээнд тархсан коронавируст цар тахал нийгмийн амьдралыг урьдчилан төсөөлшгүй хүнд нөхцөл байдалд оруулж, хүний аж амьдралын уламжлал хэвшил, эдийн засагт ихээхэн өөрчлөлтийг авч ирэхийн зэрэгцээ улс орнуудын төрөл мэргэжлийн салбар байгууллага, институтийн өмнө том сорилтыг авч ирлээ.

Энэ нь нэг талаас нийгмийн удирдлага, засаглалын чадавх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо, үр ашигтай удирдлагын шалгуур, нөгөө талаас цар тахлын нөхцөл байдалд хүний эрхийн суурь ухагдахууныг хөндсөн, эрх зүйн хөгжилд ташуур өгсөн шударга ёсны сорилт болж байна.

Судалгааны багийн гишүүд цар тахлын үеийн аль нэг фактад суурилан судалгааны өрөөсгөл хандлага гаргахаас сэргийлж аливаа хууль хэрэгжих онцгой цаг үе тулж ирэхэд уг хууль нь ямар хууль вэ? гэдгийг үнэлэн шинжлэх, эрх зүйн онолын үүднээс харьцуулах шаардлагатай гэж үзэв.

Иймд судалгааны ажлын арга зүйг цар тахалтай тэмцэх чиглэлээр гарсан хууль, эрх зүйн актыг судлах, хэрэгжилтэд хэсэгчлэн дүн шинжилгээ хийж харьцуулан судлахад чиглүүлсэн

² Бүгд Найрамдах Солонгос Улс 2015 онд MERS халдварт өвчин тархах үед эрх баригчид хэд хэдэн агентлаг байгууллагыг шинээр байгуулж халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ авсан боловч тэдгээр нь халдварт өвчинтэй тэмцэх чиглэлд хамтран ажиллах тодорхой заавар, журамгүй байгууллагуудын эрх үүрэг давхацсан шинжтэй байсан ба Солонгосын Өвчний Хяналт, Урьдчилан сэргийлэх Төв нь гол чиглүүлэгч байгууллага байсан хэдий ч эрх зүйн зохицуулалт нь сул байсан тул бусад байгууллагыг удирдан ажиллах боломжгүй байсан. Энэ алдааг засаж БНСУ Халдварт өвчнийг Хянах ба Урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулж сайжруулсан тул өмнөх алдаагаа давтаагүй байна. Энэ талаар “South Korea’s Success Against COVID-19” The Regulatory Review <https://www.theregreview.org> -аас дэлгэрүүлэн үзэж болно.

болно. Учир нь “...эрх зүй нь шударга ёсыг агуулдаг бол эрх зүйн тогтолцоо гэдэг бол хүмүүсийн хооронд үүссэн маргаанд шударга ёсыг хэрэглэх тогтолцоо” [бөгөөд] “эрх зүй нь шударга ёсыг хийгээд дотоод үнэт зүйлсэд тэмүүлэхээс илүү [эрх зүй] өөрөө зөв зарчим дээр тулгуурлан угсрагдсан байх ёстой” хэмээн эрх зүйн философич Лон Фуллер “*The Morality Of Law*” бүтээлдээ толилуулжээ.³

Цагдаагийн байгууллага нь нийгэмд хууль тогтоомжийг сахиулж, шаардлагатай үед албадан сахиулах онцгой эрхтэй, нөгөө талаар иргэдтэй нүүр тулж харьцах шаардлагатай субъектийн нэг тул цагдааг хууль, эрхийн актын “чанар шалгагчтай” зүйрлэн ойлгож болно.

Коронавируст (COVID-19) цар тахлын үед цагдаагийн байгууллагын өмнө тулгарч буй сорилтыг бүхэлд нь авч үзэх боломжгүй бөгөөд энэ нь хэт өргөн сэдвийг хөндөнө. Цагдаагийн байгууллага, алба хаагч хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бусад үүргийг хэрэгжүүлэх, алба хаагчийн аюулгүй байдал, халдвараас хамгаалах зэрэг олон чухал асуудал байх ч тэдгээр нь тус бүрдээ нарийвчилсан судалгаа, эргэцүүлэл шаардаж байгааг судлаачид, эрдэмтэд анхааралдаа авч энэ талаар тухайлсан судалгаа хийгдэх биз ээ.

Улс орон бүрийн цагдаагийн байгууллагад тэдгээр сорилт нь зарим тохиолдолд шийдвэр гаргахад мухардах нөхцөл байдалд хүргэж, ажлын хэт их ачаалал, халдварын хамгийн өндөр эрсдэл бүхий ажлын байрны онцлогоос шалтгаалан алдаж бас өвдөж болохгүй гэсэн иргэн хүний болон тангараг өргөсөн цагдаагийн алба хаагчийн хувьд үүрэх сэтгэл зүйн дарамтаар илэрч байна. Цагдаагийн алба хаагч, иргэн хоорондын харилцааны асуудал энэ цаг үед ямар байгааг тандан судлах, хэрэв сөрөг үр дагавар эсвэл хүндрэл бэрхшээл байвал чухам юунаас голлон үүдэж байгаа болохыг энэхүү бодлогын судалгаагаар нотлон харуулахыг зорив.

³ М.Батсуурь, Ч.Өнөрбаяр Эрх Зүйт Ёс, “Modern ‘IUS Natural’ буюу орчин үеийн жам ёсны эрх зүйн онолын зарим асуудал” УБ., 2011. 30 дахь тал

Бид судалгааны ажлыг коронавирусын халдвар дотоодод илэрч “улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжиж хязгаарлалтын дэглэм тогтоосон нөхцөлд хийж гүйцэтгэсэн тул зарим мэдээлэл, баримт цуглуулахад хүндрэл учирч, ялангуяа иргэдийн болон цагдаагийн алба хаагчийн ойлголт, сэтгэл зүйг тодорхойлох фокус ярилцлага хийх, төрийн албан тушаалтантай уулзалт хийх зэрэг боломж хязгаарлагдмал байсныг дурдаж судалгааг сонирхогч Танаас хүлцэл өчье.

Судалгааны ажлын зорилго

Судалгааны баг “Цар тахалтай тэмцэх ажилд манай улс ямар хууль эрх зүйн актыг голлон мөрдөж байна вэ?”, “Цагдаагийн байгууллага, алба хаагч цар тахалтай тэмцэх ажилд ямар үүрэгтэй оролцож байна вэ?”, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед цагдаагийн алба хаагч хуульд зааснаас гадна нэмэлт эрх эдлэх үү?”, “Алба хаагчдын ажлын ачаалал хэр их байна, үүрэг гүйцэтгэхэд энэ нь нөлөөлж байна уу?”, “Иргэдийн зарим эрхийг хязгаарлаж буй “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм” гэж юу вэ, ямар хуулиар уг харилцааг зохицуулж байна вэ?” гэх зэрэг асуултад хариулт олохын тулд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд дүн шинжилгээ хийлээ. Үүний тулд дараах зорилгыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Коронавируст (COVID-19) цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хорио цээрийн дэглэм⁴ тогтоосон үед цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх үүргийг тодорхойлсон хууль, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
- Цар тахалтай тэмцэх ажлыг зохицуулж байгаа хууль, эрх зүйн акт, бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлж

⁴ Судалгаагаар хорио цээрийн дэглэм гэж нийтээр ярьж, эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэр ч гэсэн хууль зүйн ташаа ойлголт, буруу нэр томъёо ашиглаж байгааг судалгааны 2 дахь хэсгээс танилцана уу.

буй “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм”-ийн ойлголт, эрх зүйн зохицуулалт, хэрэгжиж буй байдал, цагдаагийн байгууллагын үүрэг, оролцоонд дүн шинжилгээ хийх;

- Бүх нийтийн бэлэн байдлын үед цагдаагийн алба хаагч тодорхой үйл ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх эрх зүйн үндэслэлийг тодорхойлох зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй, аргачлал

“Цагдаагийн байгууллага, алба хаагч бүх нийтийн бэлэн байдлын үед мөрдөж ажиллах хууль, дүрэм, журмын хэрэгжиж буй байдал” гэсэн сэдвийн хүрээнд судалгааны баг коронавируст (COVID-19) цар тахал гэж юу болох?, хэчнээн улс оронд тархаж ямар хэмжээний хохирол учраад байна вэ?, дэлхий нийт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр ямар ямар арга замаар тэмцэж байна вэ?, ямар хууль эрх зүйн зохицуулалт үйлчилж байна вэ? гэх зэрэг ерөнхий ойлголтыг судалж, цуглуулсан мэдээллийн хүрээнд харилцан ярилцаж нэг ойлголтод хүрснээр энэхүү судалгааны ажлын агуулгыг тодорхойлсон болно.

Судалгааны ажлын агуулгын дагуу албаны эх сурвалжаас холбогдох тоо баримт, тайлан, судалгаа шинжилгээний ажлын материал, нийтэд нээлттэй эх сурвалжаас эрх зүйн баримт бичиг, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрүүдийг цуглуулах, ангилах, тэдгээрт тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулж, хууль тогтоомж, дүрэм журмуудын онол эрх зүйн үндэслэл, бүрдэл, уялдаа холбоо зэргийг тодорхойлох, харьцуулах, арга замаар хууль зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, түүнийгээ санал асуулгын дүнгээр шинжлэн баталгаажуулах аргачлалаар судалгааны ажлыг хийлээ.

НЭГ. ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧИЙН ОРОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны багийн гишүүд цагдаагийн байгууллага, алба хаагчид коронавируст (COVID-19) цар тахлын үед ямар үүрэг гүйцэтгэж, эрх эдлэх вэ гэдэг асуудалд судалгааны гол анхаарлыг хандуулав.

Манай улс коронавируст (COVID-19) цар тахлын халдварын тохиолдол дэлхий улс орнуудад гарч эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх⁵ хугацаанд хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд хууль тогтоомжид заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зарим төрлийн үйлчилгээг зогсоох, иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэх мэт олон талт арга хэмжээг хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт шалгалт хийх, иргэдэд мэдээлэх, уриалах арга замаар хэрэгжүүлж байна.

Дээрх чиглэлд Улсын Их Хурал (УИХ) шинээр Коронавируст халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 оны 4 дүгээр сард батлан гаргасан. Уг хууль батлагдсантай холбогдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг тус тус баталсан.⁶

Эдгээрээс гадна эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 358 зүйл, заалт бүхий 67 эрх зүйн актыг гаргажээ. Тухайлбал, Монгол

⁵ Судалгаанд ашигласан хууль, эрх зүйн актыг 2020.01.01-2020.12.01-ний өдрийн байдлаар авсан болно.

⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 он, №17 /1119/

Улсын Ерөнхийлөгчийн зарлиг нэг⁷, УИХ-ын тогтоол тав⁸, Засгийн газрын тогтоол гучин найм,⁹ Улсын онцгой комиссын тогтоол, даргын тушаал арван тав,¹⁰ Нийслэлийн Засаг даргын захирамж тав¹¹, Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын бусад байгууллагатай хамтран баталсан журам нэг¹² тус тус байна. Эдгээр шийдвэрийн дийлэнх нь коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн бүх салбарт үүрэг чиглэл болгосон, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийг дэмжих агуулгатай, үүний тулд зохих этгээдийг удирдлага зохион байгуулалтаар хангасан, үүрэг болгосон шинжтэй байна. Дээр дурдсан 358 зүйл, заалтыг ангилан үзвэл:

1. Эдийн засаг, хөрөнгө санхүү, шаардлагатай тоног төхөөрөмж шийдэх тухай – 90;
2. Дүрэм, журам, эрх зүйн акт батлан гаргахтай холбоотой – 15;
3. Бэлэн байдлын зэрэг тогтоох, хугацаа сунгах, бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын талаар – 109;
4. Аливаа үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан, зөвшөөрсөн тухай – 86 заалт тус тус байна.

Цар тахалтай тэмцэх чиглэлээр шинээр батлагдан гарсан хууль, эрх зүйн актуудаас цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль сахиулах үйл ажиллагаанд хамааралтай хэсэгт судалгаа-шинжилгээ хийж үзэхэд ЦЕГ-ын даргад нэр зааж үүрэг болгосон

⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, 2020.02.12-ны өдрийн №10

⁸ Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2020.04.09-ний өдрийн №21, 2020.04.29-ний өдрийн №31, 32, 2020.05.15-ны өдрийн №58, 2020.10.29-ний өдрийн №31

⁹ Ашигласан материалын жагсаалт 4-өөс үзнэ үү

¹⁰ Ашигласан материалын жагсаалт 4-өөс үзнэ үү

¹¹ Нийслэлийн засаг даргын захирамж, 2020.03.30-ны өдрийн а/436, 2020.06.30-ны өдрийн а/930, 2020.11.11-ний өдрийн а/1241, 2020.11.12-ны өдрийн а/1242, 2020.11.18-ны өдрийн а/1248

¹² ЦЕГ-ын дарга, ХХЗХ-ны даргын 2020.08.27-ны өдрийн А/200, А/169 дугаарын хамтарсан тушаал “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам батлах тухай”

зүйл заалт 11, цагдаагийн байгууллага, алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хяналт тавих, хэв журам сахиулахад хамаарал бүхий зүйл заалт 37 байна. Тухайлбал, Нэр зааж үүрэг болгосон 11 зүйл заалтыг эх сурвалжаар авч үзвэл:

1. Засгийн газрын тогтоол – 2
2. УОК-ын шийдвэр - 6
 - а. УОК-ын дарга, Шадар сайдын тушаал - 1
 - б. УОК-ын тогтоол - 5
3. Нийслэлийн Засаг даргын захирамж - 1 байна.

ЦБ-ын чиг үүрэгт хамаарал бүхий 37 зүйл, заалтыг эх сурвалжаар нь авч үзвэл:

1. Ерөнхийлөгчийн зарлиг - 1
2. Засгийн газрын тогтоол - 6
3. УОК-ын шийдвэр - 6
 - а. УОК-ын даргын тушаал - 2
 - б. УОК-ын тогтоол - 4
4. Нийслэлийн Засаг даргын захирамж - 3 байна.

Цагдаагийн байгууллага нь цар тахалтай тэмцэхтэй холбоотой дээр дурдсан шинэ эрх зүйн орчинд нийгмийн дэг журмыг сахиулахын зэрэгцээ бусад хууль тогтоомжоор хариуцуулсан үүргийг Цагдаагийн албаны тухай хууль (ЦАТХ)-аар олгогдсон эрх хэмжээний хүрээнд биелүүлэн ажиллаж байна.

Мөн Улсын онцгой комисс (УОК) цар тахлын үед 35 удаа хуралдаж, хурлын тэмдэглэлээр салбар байгууллагын дарга нарт 417 зүйл, заалтын хүрээнд үүрэг чиглэл өгч, 3 албан даалгавар явуулжээ. Энэ нь нэг талаас УОК-ын идэвхтэй үйл ажиллагааг илэрхийлж байгаа боловч хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг нь цагдаагийн байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхийг идэвхжүүлсэн, зарим асуудлыг анхааруулсан, хариуцлагатай байхыг шаардсан, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг даалгасан зэрэг удирдлага, зохион байгуулалтын шинжтэй гэдгийг дурдах нь зүйтэй.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой гарсан шинэ эрх зүйн зохицуулалт болон бусад хууль тогтоомжид

заасан хөл хорио, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал зэрэг ойлголтын талаар судалж, эдгээр нь ямар журмаар хүний эрхийг хязгаарладаг, өөр хоорондоо ямар ялгаатай болохыг тодорхойлсноор цар тахалтай тэмцэхэд цагдаагийн байгууллага, алба хаагчийн оролцоо, эрх, үүргээ хэрэгжүүлж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх нөхцөл бүрдэнэ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ердийн үеэс ялгаатай эсэх, цар тахалтай тэмцэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд цагдаагийн алба хаагч хуульд заасан албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл журам нэгэн адил үйлчлэх эсэх, цагдаагийн алба хаагч цар тахалтай тэмцэхтэй холбоотой хууль, эрх зүйн актаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд тулгарч буй бэрхшээл, иргэн цагдаагийн алба хаагчийн харилцаанд маргаан үүсгэж байгаа зарим шалтгаан нөхцөлийг шинээр гарсан хууль, эрх зүйн актуудыг судалж үзсэнээр тодорхойлогдож байна.

1.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

Цар тахалтай тэмцэх чиглэлээр шинээр гарсан хууль, бусад эрх зүйн актаар цагдаагийн байгууллага, алба хаагчид олгосон эрх үүрэг, оролцоог болон хүний эрхийг хязгаарласан шийдвэрийг ямар горим журмаар хэрэгжүүлж байгааг, ингэхдээ цагдаагийн алба хаагч албадлагын арга хэмжээ хэрэглэх нэмэлт¹³ хууль зүйн үндэслэл журам бий эсэхийг тодруулахыг зорив.

Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг (Цар тахлын хууль гэх) батлан гаргаж

¹³ Цагдаагийн алба хаагч албадлага хэрэглэх эрх ЦАТХ-д тусгагдсан байх ба энд цар тахалтай тэмцэх үед шинээр нэмсэн эсэх талаар дурдсан болно.

мөрдүүлж байна. Энэ хууль батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчлэх хугацаатай. Уг хууль нь 4 бүлэг 19 зүйлтэй ба хуулийн 1 дүгээр зүйлд “...цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн хуулийн зорилтыг тодорхойлжээ.

Хуулийн бүлэг, хэсэг, зүйл, заалтад тусгагдсан хэм хэмжээг судлахад цар тахлын үед нийгэм эдийн засгийн арга хэмжээ авах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад төрөөс тодорхой хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийн, эм, эмнэлгийн нөөц хангамж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар болон банк санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаар эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, хамгаалахтай холбоотой олон харилцааг зохицуулсан. Хуульд цар тахлын үед хүний эрхийг хангах талаар болон ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг зарчмуудыг тодорхой хуульчилсан нь сайшаалтай.

Уг хуулиар зохих байгууллага, албан тушаалтанд тодорхой журам, зааврыг батлан гаргах эрх олгосон байна.¹⁴

Тус хуулийн дагуу батлан гаргах журам, заавар нь цар тахлын үеийн харилцааг зохицуулах шаардлага хангахуйц, Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актын шаардлагыг хангасан байх ёстой.

Тэрчлэн, цар тахлын үед тэдгээр журам, зааварт зааснаар хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх тул нэг талаас цагдаагийн байгууллага, алба хаагчийн гүйцэтгэх эрх, үүргийг тодорхой

¹⁴ Хуульд хүний тодорхой эрхэд хязгаарлалт тогтоосон хэм хэмжээ тусгагдаагүй, харин “...хүний тодорхой эрхэд хязгаарлалт хийх ... асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж зааснаас үзэхэд эрх бүхий субъектүүд журам батлан гаргах замаар хүний тодорхой эрхэд хязгаарлалт хийхээр ойлгогдож байна.

тусгах, нөгөө талаас цар тахлын үед ялангуяа бүх нийтийн бэлэн байдлын үед иргэдэд зөвшөөрөгдөх, хязгаарлагдах нөхцөлийг тодорхой тусгасан байх, түүнийг хууль сахиулагч хэрэгжүүлэн ажиллах арга ойлгомжтой журамлагдсан байвал зохино.

Цар тахлын хуулийн зорилгод “...хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх...” харилцааг зохицуулахад оршино гэж заасан боловч энэ талаар хуульд нарийвчлан журамласан зохицуулалт байхгүй байна. Харин хуулийн 15 зүйл, заалтад журам батлан гаргах эрхийг зохих албан тушаалтанд шилжүүлэн олгосон байх бөгөөд үүнээс цагдаагийн байгууллага хариуцан гаргах 1 журам байна. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13-т “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэж заасны дагуу энэ журам батлагдан гарчээ. Харин бусад 14 журам батлагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Цар тахалтай тэмцэх хууль нь хэрхэн хэрэгжих процессын заалтгүй, мөн хуулиар батлан гаргахыг заасан журмууд нь бүрэн гүйцэд батлагдаагүй нь цагдаагийн байгууллагаас цар тахлын үед энэ хуулийг хэрэгжүүлэн сахиулах ажиллагааг ойлгомжтой, ил тод болгоход саад учруулж байна. Өөрөөр хэлбэл, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдийн ямар эрх хязгаарлагдаж байгаа нь тодорхойгүй байна. Нөгөө талаас, цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүрэг тодорхой бус үлдсэн. Үүнээс улбаалан цагдаагийн алба хаагч хязгаарлалтын дэглэм сахиулах үед шийдвэр гаргаж чадахгүй мухардалд хүрэх, буруу шийдвэр гаргах, журам тодорхой бус байдлаас үүдэн иргэдэд буруу шаардлага тавих, үр дүн, ач холбогдол багатай эргүүлийн чиглэл, маршрут ихээр гаргаж цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж алба хаагч бухимдах, иргэдэд зүй бус үг хэллэг, өнгө аясаар шаардлага тавьж харилцааны маргаан, зөрчил үүсгэх зэрэг сөрөг үр дагавар үүсэж байна.

Судалгааны ажлын хүрээнд аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагын 8 алба, нэгжийн нийт 1,065 алба хаагч хамрагдсан

24 асуулт бүхий “санал асуулга”-ыг зохион явуулж дүнг нэгтгэсэн болно.

Санал асуулгад оролцогчдын 328 буюу 30.8 хувь нь Засгийн газар (ЗГ), онцгой комиссоос гаргасан шийдвэр иргэдийн амьдралын зайлшгүй хэрэгцээг зохицуулж чадахгүй хүндрэл учруулж байгаа бөгөөд үүнээс шалтгаалан алба хаагчаас тавьсан шаардлагыг иргэд биелүүлэхгүй байна гэж; мөн санал асуулгын явцад “... Хөдөлгөөн хязгаарласнаа ойлгомжтой болгож, хэвлэл мэдээллээр цацаач ээ, иргэд ямар ч мэдээлэлгүй байна, ...Явган эргүүл одоо юу хийхээ сайн мэдэхгүй байна, ...Автобусны буудал дээр цагдаа хэчнээн шаардлага тавьж зай хоорондыг сахиулж байгаа хэдий ч автобусанд ороод дэглэм алдагдаж байна, ...Байгууллагууд уялдаа холбоо байхгүй, ЗГ холбогдох газраас гаргаж байгаа тогтоол шийдвэрүүд тодорхойгүй бөөрөнхий, ...Бэрхшээлтэй асуудал шийдвэр л байна. Бусдаар цүрэг гүйцэтгэх хэвийн...” гэх зэргээр саналаа илэрхийлсэн нь Гамшгаас хамгаалах тухай болон Цар тахалтай тэмцэх хуулийн процессын заалт дутагдалтай, хуулиар эрх шилжүүлэн авсан эрх бүхий этгээд нь батлан гаргавал зохих журмуудыг¹⁵ гаргаагүй байгаа нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн цар тахлын үед нийгмийн дэг журмыг сахиулах ажлыг тодорхой бус болгож байна.

Түүнчлэн, судалгааны явцад алба хаагчдаас олон тооны саналыг гаргасан байх бөгөөд ерөнхий агуулга, давтамжийн хувьд (i) Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэр нэг мөр, тэнцвэртэй байх, (ii) Удирдлагаас өгөх үүрэг даалгаврын давхцалыг арилгах, эргүүлийн цагийг чанартай богино байлгах, (iii) Алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авах, халдвар хамгааллын хувцас, хэрэглэлээр хангаж өгөх талаар хүсэлт гаргаснаас үзэхэд эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрүүд өөр хоорондоо зөрчилдөх, удирдлага зохион байгуулалтын ажилд алдаа дутагдал гарах, цар тахлын халдварын

¹⁵ Гамшгаас хамгаалах тухай хууль-(Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2 хэсэг, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 хэсэг

эрсдэлт нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх сөрөг үр дагаварт хүргэж болзошгүйг харуулж байна.

Судалгаанд хамрагдагчдын 82.5 хувь нь “Засгийн газар, Улсын онцгой комисс, Улсын Их Хурлын шийдвэрийн хүрээнд шууд удирдлагаас өгсөн үүргийг хэрэгжүүлж байна..”, “.95.5 хувь нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, өгч буй үүрэг, ажлын чиглэл нь ойлгомжтой байна..” гэж хариулснаас үзэхэд цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийн зүйл заалтыг бус ЗГ, УОК, Нийслэлийн онцгой комисс (НОК), Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрийг баримталж ажиллажээ гэж дүгнэж болохоор байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэд амьдралын зайлшгүй хүндэтгэн үзэх шаардлагаас үүдсэн зорчих хөдөлгөөн хийх боломжгүй болсон мэт төөрөгдөлд орох, нийгмийн дэг журам сахиулж буй цагдаагийн ажилтан ямар хууль, эрх зүйн актын үүднээс бусдын хөдөлгөөнийг хязгаарлаж, хориглож байгаагаа ойлгоогүйн улмаас иргэд цагдаагийн алба хаагчдын хооронд зарим тохиолдолд гомдол, маргаан үүсэж байна. Зөвхөн иргэн цагдаагийн алба хаагчийн хооронд маргаан үүсээд зогсохгүй хүний эрх ноцтой зөрчигдөж, хохирч байгаа тохиолдлууд гарсан. Тухайлбал, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Сэлэнгэ аймгийн харьяат 10 настай иргэн “Н” Улаанбаатар хот руу яаралтай нэвтэрч чадаагүйн улмаас эмнэлэгт нас барсан, мөн 12 дугаар сарын 7-нд Эмээлт шалган нэвтрүүлэх постын орчимд иргэн “О” Улаанбаатар хот руу орох үедээ эмнэлгийн тусламж авч чадалгүй нас барсан хэрэг цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаагаар илэрч байна.

Цар тахлын хуульд хуулийн зорилгоо хангах процессын заалт дутагдалтай, уг хуулиар гарах тодорхой журмууд батлагдан гараагүй нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн цар тахлын үед нийгмийн дэг журмыг¹⁶ сахиулах ажлыг тодорхой бус болгож,

¹⁶ ЦАТХ-ийн 45 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага гамшгийн болон хорио цээрийн дэглэмийн үед нийгмийн дэг журмыг сахиулах үүрэгтэй гэж заасан ба энэ нь тухайн сахиулах дэг журмыг цагдаа тогтоох бус эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр баталгаажин тогтоогдсон дэг журмыг сахиулах, мөрдүүлэх үүрэгтэй.

түүнчлэн хүний эрх тодорхой хэмжээгээр зөрчигдөж байгааг санал асуулгын дүн мөн адил харуулж байна.

Хуульд журам батлан гаргахыг зохих этгээдэд даалгасан ч тэдгээр журам батлагдан гарсан эсэх, нийтэд үе шаттай танилцуулагдан сурталчлагдсан нь илэрц судалгаагаар олдоогүй болно. Хэрэв тухайн журмууд батлагдан гарсан, түүний дагуу цагдаа хязгаарлалтын дэглэмийг сахиулж байгаа бол журмуудын ямар зохицуулалт практикт хүндрэл учруулж байгааг дүгнэж болох байв.

Иргэний эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр гаргаж байгаа шинэ хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд үнэлгээ хийх, практикт нийцэж буй эсэхийг бүртгэх ажил хангалтгүй байна. Тухайлбал, Цар тахлын хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан шийдвэр гарсан боловч хуулийн хэрэгжилтийг нээлттэй хэлэлцсэн эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

Цар тахалтай тэмцэх ажил хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр хүний зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон шийдвэр¹⁷ нь хүмүүсийн амьдралд хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх нь төрийн үүрэг юм. Цар тахлын үеийн иргэдийн гомдлыг наад зах нь дээрх шаардлагын үүднээс бүртгэж, хүлээн авсан нэгдсэн мэдээлэл байхгүй, нөгөө талаас иргэд энэ цаг үед ямар эрхтэй, ямар үүрэгтэй болохоо мэдэх боломжгүй байгаа тул хүний эрх зөрчигдсөн талаар тоо баримт цуглуулах боломж хомс байсан. Тиймээс судалгаанд өрөөсгөл хандлага гаргахаас сэргийлэх үүднээс санал асуулгын дүнд тулгуурлан дүгнэлт хийснийг дашрамд дурдъя.

¹⁷ Хүмүүс шийдвэр хүн болгонд таалагдах албагүй гэж ярьдаг. Энд шийдвэрийн таалагдах, эс таалагдах талаар бичээгүй ба эрх зүйн онол, зарчмын хувьд аливаа хууль зохицуулах гэсэн харилцаагаа зохицуулж зорилгоо хангаж байгаа эсэх, хэрэгжилт, биелэлтэд дүн шинжилгээ хийгдэх нь хуулиар зохицуулсан үүрэг. Хууль тогтоомжийн тухай хуулийг үзнэ үү.

Цахим орчинд буй иргэдийн хандалт ихэнхдээ Улаанбаатар хотод өөрсдийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр зорчих боломжийг хаасан нь буруу, нийтийн тээврээр үйлчлүүлэх нь цар тахлын халдварын эрсдэлийг нэмэгдүүлнэ гэсэн утгатай байна.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон нь иргэдийг бухимдуулж, цахим орчинд нийтийн сүлжээгээр цар тахалтай тэмцэх ажлын зохион байгуулалт муу, гаргасан шийдвэр өөр хоорондоо зөрчилтэй гэсэн шүүмжлэл дагуулсан. Энэ асуудлыг шууд зохицуулж байсан Нийслэлийн Засаг даргын захирамжийг судлан үзэхэд, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл буюу дараагийн захирамж гарах хүртэлх хугацаанд иргэдийн хувийн тээврийн хэрэгслээрээ замын хөдөлгөөнд оролцох эрх хязгаарлагдаагүй байжээ. Харин тухайн цаг хугацаанд ямар эрх зүйн актыг үндэслэн иргэдийн хувийн тээврийн хэрэгслээрээ хөдөлгөөнд оролцох эрхийг хориглож, цагдаагийн байгууллагаас Улаанбаатар хотын авто замын аль чиглэл, хэсгийг мөн ямар эрх зүйн актаар хаасан нь тодорхойгүй байна.

Цар тахлын хуульд цагдаагийн алба хаагч нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэхдээ албадлагын арга хэмжээг хэрэглэх нэмэлт эрх олгосон зохицуулалт байхгүй байна. ЦАТХ-д заасан цагдаагийн алба хаагчийн иргэнд шаардлага тавих, албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг судалгааны 3 дахь хэсгээс танилцана уу.

ХОЁР. ХӨЛ ХОРИО, ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ, ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Коронавируст цар тахлын үед хөл хорио, хорио цээрийн дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдал, хатуу хөл хорио, хязгаарлалтын дэглэм, бүх нийтийн хөл хорио гэх мэт олон үг хэллэг, ойлголт цаг үеийн шаардлагаар хэрэглэгдэж, иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэж байна. Энэ нь иргэд эрх, үүргээ мэдэхэд, хууль сахиулагчид мөн ямар горим журмаар хууль тогтоомжийг мөрдүүлэх вэ гэдэгтэй шууд хамааралтай.

Дээр дурдсан олон нэр томъёо нь хууль, эрх зүйн ялгамжтай үр дагаврыг бий болгодог. Эрх бүхий албан тушаалтан аливаа шийдвэр гаргах, олон нийтэд танилцуулах, хэвлэл мэдээллээр түгээхдээ “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм” зэрэг хуульчилсан үг хэллэг, нэр томъёог зөв ойлгож, хэрэглэхгүй байна. Тухайлбал, Засгийн газраас гаргасан эрх зүйн актад¹⁸ “...хөл хорионы дэглэм тогтоосонтой холбогдуулан...” мөн албан ёсны мэдээллийн эх сурвалжид¹⁹ “...Сэлэнгэ аймагт хатуу хөл хорио тогтоож...” гэх зэргээр олон нийтэд мэдээлэгдсэн байх ба “хөл хорионы дэглэм”, “хатуу хөл хорио” гэсэн нэр томъёо, зүйл, заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад байхгүй байна.

Цар тахлын хуульд “**хөл хорио**” гэж тодорхой хугацаанд хүн ам, газар нутгийг хамарч халдварт өвчин тархахаас сэргийлэх, халдварыг анх гарсан голомтод нь барих, хяналтад авахад чиглэсэн арга хэмжээг; Гамшгаас хамгаалах тухай хуульд “**хорио цээрийн дэглэм**” гэж цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, таслан зогсоох зорилгоор халдварласан, халдвар тээгч, халдварласан байж болзошгүй сэжиг бүхий болон тэдгээрийн

¹⁸ Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 188-р тогтоолын 1 дэх заалт

¹⁹ Засгийн газрын албан ёсны мэдээллийн эх сурвалжид нийтлэгдсэн мэдээ, Доорх холбоосоор үзнэ үү <https://zasag.mn/news/view/25580>

харьцагч, хавьтагч, хүн, мал, амьтан, эд материалыг тусгай нөхцөлд тогтоосон хугацаагаар бусдаас тусгаарлах, эмчлэх, сувилах, хяналт-ажиглалтад байлгах, ариутгахыг; “**хязгаарлалтын дэглэм**” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг тус тус ойлгохоор хуульчилж өгсөн.

Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 онд батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш нийт 2 удаа (2020.04.09, 2020.05.14) нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан бөгөөд уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад “хорио цээрийн дэглэм”, мөн зүйлийн 4.1.23 дахь заалтад “хязгаарлалтын дэглэм”-ийн тухай ойлголтыг шинээр нэмж тус тус хуульчилжээ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор аливаа үйл ажиллагааг зогсоох болон хориглох, хязгаарлах чиглэлээр гаргасан зарим шийдвэрийн эрх зүйн үндэслэл, үг хэллэг оновчтой бус, хориглох, хязгаарлах үйл ажиллагааг ямар дүрэм, журмын хүрээнд явуулахыг тодорхой зааж өгөөгүй байна.

Түүнчлэн төрийн байгууллага, алба хаагчаас шийдвэрт дурдагдаагүй арга хэмжээг өөрсдийн санаачилгаар, эсхүл амаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн байж болох нөхцөл байдал захиргааны актуудыг судлах явцад илэрч байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор²⁰ улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн төмөр замын дамжин өнгөрөх, улс, хот хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспорт болон зөвшөөрөгдсөн 11 төрлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг хориглосон шийдвэр гаргасан.

Засгийн газрын тогтоолд үүрэг болгосны дагуу Нийслэлийн засаг дарга А/1242 тоот захирамжаар нийтийн тээврийн үйлчилгээ, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй

²⁰ Засгийн газрын 2020 оны 11 сарын 11-ний өдрийн 178-р тогтоол

хүнсний худалдааны газрын ажиллах цагийн хуваарь болон зөвшөөрөгдөөгүй авто тээврийн хэрэгслийг авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод орох гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, согтууруулах ундаа худалдах, зөвшөөрөгдсөн 13 төрлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан бөгөөд “...зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэд, оршин суугчдад уриалсугай...” гэжээ.

Тус захирамжаар иргэд, ялангуяа Улаанбаатар хотод оршин суугчдын зорчих хөдөлгөөнийг хязгаарлаагүй байна. Уг шийдвэр хэрэгжсэнээс хойш 6 хоногийн дараа нийтийн тээврийн үйлчилгээний тогтоосон цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, бусад цагт явган хүн, автомашины хөдөлгөөнийг хязгаарлах, “... бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлтийг шөнийн цагаар зохион байгуулах” шийдвэрийг гаргажээ.

Мөн УОК-ын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор “...нийслэлээс гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөн...”-ийг зогсоох шийдвэрийг гаргасан байна.

“Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах”-тай холбоотой харилцааг Засгийн газрын баталсан журмаар²¹ зохицуулахыг Гамшгаас хамгаалах тухай хуульд зааж өгсөн боловч уг журам нь мөн л батлагдсан болон мөрдөгдөж байгаа эсэх нь тодорхойгүй, олон нийтэд ил тод, нээлттэй биш байна. Журам батлагдсан бол “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэгт шилжсэн үед иргэдэд бодитоор тулгарч байгаа олон асуудлыг зохицуулж болохоор байна. Жишээлбэл, аль замыг хаасан, ямар замаар хэн зорчиж болох, зайлшгүй хүндэтгэн үзэх шаардлага гарсан иргэн эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, ойр дотнын хүн нас барах, бага насны хүүхэд харах хүнгүй үлдэх гэх мэт тохиолдолд хэнээс зөвшөөрөл авах, хаана хандах, түүнийгээ яаж нотлох, цагдаагийн алба хаагч тийм хүндэтгэн үзэх шалтгаан мөн болохыг хэрхэн

²¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн (Шинэчилсэн найруулга) 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг “Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах журмыг Засгийн газар батална.

яаж шалгах, ямар шийдвэр гаргах зэрэг асуудлууд тодорхой бус байлаа.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад судалгаа хайлт хийхэд “Хөл хорио” гэсэн үг хэллэгийг 1, “Хорио цээрийн дэглэм” гэсэн үг хэллэгийг 9, “хязгаарлалтын дэглэм” гэсэн үг хэллэгийг 4 хуульд тус тус хуульчилжээ.

Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтнаас хязгаарлалтын дэглэм тогтоох чиглэлээр гаргаж буй захиргааны актын хууль зүйн үндэслэл оновчтой бус, шийдвэрийн заалт, үг хэллэг ойлгомжгүй, хориглох, хязгаарлах үйл ажиллагааг ямар дүрэм, журмын хүрээнд явуулах нь тодорхойгүй байгаа нь цагдаагийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаанд төдийгүй, цагдаагийн алба хаагч болон иргэдийн дунд үл ойлголцол, хэрүүл, маргаан гарах, цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хуулийн дагуу гарах аливаа шийдвэр, арга хэмжээ нь (i) хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх, (ii) үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх, (iii) өмнө дурдсан зорилгод хүрэхэд зайлшгүй, тухайн нөхцөлд тохирсон тодорхой хүрээ, хугацаатай байх, (iv) хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн Хуулийн заалтыг хөндөөгүй байх гэсэн шаардлагуудыг нэг мөр хангасан байх тухай 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр УИХ-аас баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Цар тахлын хуульд тус тус хуульчилсан²² боловч бодит байдал дээр хэрэгжихгүй байна.

²² Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он, 10 дугаар зүйлийн 10.9 хэсэг, “Цар тахлын хууль”, 2020 он, 11 дүгээр зүйлийн 11.1

ГУРАВ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ЭРХ, ҮНДЭСЛЭЛ

Цар тахалтай тэмцэх шинэ хууль, эрх зүйн зохицуулалтыг судлахад цагдаагийн алба хаагчдын хариуцан сахиулах хязгаарлалтын дэглэм тодорхой бус, дэглэмийг хэрхэн сахиулах тухай дэг, горим буюу журам байхгүй байна. Дэг, горим буюу журам бол тогтоосон хууль, эрх зүйн хэм хэмжээг сахиулан мөрдүүлэх үйл ажиллагааны дараалал, арга зам нь (процесс, процедур) юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг сахиулахдаа баримтлан ажиллах журам нь цагдаагийн алба хаагчийн эрх мэдлийг бүрдүүлэх хүчин зүйл биш, хууль тогтоомжийг хууль ёсны дагуу хэрэгжүүлэх арга зам нь болно.

Харин хууль тогтоогч болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан эрх зүйн акт нь цагдаагийн алба хаагчид эрх мэдэл (*police power*) олгодог. Цагдаагийн алба хаагчийн эрх мэдэл нь ийнхүү хууль тогтоомжоор хариуцуулсан үүргээр илэрхийлэгдэхийн зэрэгцээ түүнийг хэрэгжүүлэх, сахиулан мөрдүүлэх явцад хуулиар тусгайлан олгосон эрх үүргээр хэрэгжинэ. ЦАТХ-д²³ цагдаагийн алба хаагчид тусгайлан олгогдсон эрх, үүрэг тодорхой тусгагдсан байна. Тухайлбал, уг хуульд заасны дагуу “цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэх... үүрэгтэй” гэж заасан.²⁴

Мөн хуульд цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалгах, шийдвэрлэхэд “хүний бичиг баримтыг шалгах”, “түр саатуулах”, орон байр бусад газарт нэвтрэн орох, үзлэг хийх, эд зүйл бичиг баримтыг түр

²³ Цагдаагийн албаны тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам”, мөн хуулийн Тавдугаар бүлэг “Албадлагын арга хэмжээ хэрэглэх”-ийг тус тус үзнэ үү.

²⁴ Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2

хураан авах, тээврийн хэрэгслийг зогсоон шалгах зэрэг тодорхой ажиллагааг явуулах” эрхийг олгосон байна. Цар тахалтай тэмцэхэд зориулан шинээр батлан гаргасан хууль, эрх зүйн актын хүрээнд цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх журамд нэмэлт, өөрчлөлт ороогүй тул ЦАтХ-д зааснаар хэрэгжинэ.

Хорио цээр, хязгаарлалтын дэглэм, холбогдох бусад журам, заавар болон Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцох талаар Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулсан.²⁵

Хууль зүйн ерөнхий үүргээрээ бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийг сахиулах нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүрэг хийгээд Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.13-т зааснаар гамшгаас хамгаалах улсын байцаагчийн болон цагдаагийн байгууллагын харьяалах шалган шийдвэрлэх зөрчил мөн.

Уг заалтыг цагдаагийн алба хаагч хэрэгжүүлэхэд хорио цээрийн дэглэм, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрт тусгасан зөвшөөрсөн болон хориглосон зүйл нь тодорхой байх шаардлагатай. Хэрэв тэрхүү дэглэм, хүний хөдөлгөөний хязгаарлалтыг хууль, эрхийн актаар тодорхой зохицуулаагүй бол (i) Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.13-ыг²⁶ цагдаагийн алба хаагч хэрхэн сахиулах нь тодорхой бус болно, (ii) уг зүйлээр хамгаалагдсан харилцааг зөрчсөн гэх үйлдэл тодорхойлогдохгүй юм.

Энгийнээр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд “гамшиг, халдварт өвчний үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шийтгэл оногдуулахаар хуульчилсан” боловч дэглэм, хязгаарлалт тогтоосон

²⁵ Зөрчлийн тухай хуулийн 5.13 зүйл Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих, Эрүүгийн хуулийн 15.6 зүйл Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус тараах

²⁶ Зөрчлийн тухай хууль, 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт

хууль, эрх зүйн хэм хэмжээний зохицуулалт хангалтгүй, журам тодорхой бус байна.

Бид цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой шинээр бий болсон хууль, эрх зүйн актад дүн шинжилгээ хийж, тэдгээрт хүний хөдөлгөөний хязгаарлалтын талаар тодорхой зохицуулалт бүхий журам дутагдалтай байгааг тайлангийн өмнөх хэсгүүдэд дурдсан. Тэгэхээр цагдаагийн алба хаагч бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийг сахиулах үедээ юуг, ямар үйлдлийг зөрчилд тооцож, иргэдийн ямар үйлдлийг хязгаарлаж, хориглох вэ? гэдэг нь тодорхойгүй байна гэсэн үг юм.

Хорио цээрийн дэглэм, гамшгийн үеийн хязгаарлалтын дэглэм тодорхой бусыг харуулах үүднээс логик асуултаар жишээлэн шалгая.

1. Хэв журам сахиулах чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч олноор бөөгнөрсөн хүмүүстэй гудамж талбай, олон нийтийн газарт тааралдвал ямар хууль, эрхийн актаар тэдгээрийг байгаа газраа орхин явахыг шаардах вэ? Тэдгээр хүмүүс цар тахалтай тэмцэхтэй холбогдуулан гаргасан ямар хууль, эрх зүйн актыг зөрчиж байна вэ?

Дээрх тохиолдолд одоогоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед гудамж талбайд олноор бөөгнөрөн цугларахыг хориглосон шийдвэр гараагүй байна. Хориглосон заалттай журам байхгүй. Харин иргэдийг гэртээ байхыг л уриалсан. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хамгийн чухал арга хэмжээ нь хүмүүсийг нэн шаардлагатай биш тохиолдолд олуулаа нэг дор цуглахгүй байхыг уриалахын зэрэгцээ бас хууль тогтоомжоор хориглож хязгаарлах арга хэмжээг олон улс оронд авч хэрэгжүүлж байна.

2. Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд хувийн автомашинаар оролцож байсан иргэнийг 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар төсөөлөн авч үзье.

Замын хөдөлгөөнд оролцож буй иргэнийг аль нэг уулзвар дээр ирэхэд цагдаагийн алба хаагч уулзварын хөдөлгөөнийг хааж, түүнийг нэвтрэхийг хориглон, буцаж явах, эсвэл зөвхөн баруун гар тийш эргэж явах шаардлага тавьжээ. Цагдаагийн алба хаагчийн шаардлага, шийдвэрийн хууль тогтоомжийн үндэслэл нь юу вэ?

Энэ тохиолдолд зам, зорчих хэсэгт хязгаарлалт тогтоосон тухай Цар тахлын хуулийн заалт болон эрх бүхий этгээдээс тогтоосон эрх зүйн хэм хэмжээний акт байхгүй байна.

ЦАТХ-ийн 45 дугаар зүйлд “цагдаагийн байгууллага гамшиг, хорио цээрийн дэглэм сахиулах хүрээнд нийтийн хэв журам хамгаалах, гэмт, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хэлбэрээр хяналт тавина” гээд мөн зүйлийн 45.1.1-д ”зөвшөөрөгдсөн цэг, зурвасаас бусад газраар хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх” гэж заасан байна.

Цагдаагийн алба хаагч энэ заалтыг баримтлан ажиллахад эрх бүхий этгээд захиргааны акт (засаг даргын захирамж)- д хязгаарлалт тогтоох зам, гудамжны чиглэл зэргийг нэр зааж тодорхой тусгасан байх шаардлагатай.Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага тухайн захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх бүхий субъект биш бөгөөд зөвхөн эрх бүхий этгээдээс тогтоосон хэм хэмжээг сахин мөрдүүлэх, хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шалган шийдвэрлэх үүрэгтэй.

ДӨРӨВ. ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ШИНЭ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ОРНУУДЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА

4.1. Англи Улс

Коронавируст (COVID-19) цар тахлын аюул дэлхий дахинд нүүрлэж, халдварт вирусийн хор аюул, учруулж буй хохирлыг дүгнэн тооцсон, урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд үнэмлэхүй ололт амжилт гаргасан улс орон байхгүй байна. Харин улс орон бүр шинжлэх ухааны ололт амжилт, хууль, эрх зүй, нийгэм эдийн засаг, соёл иргэншлийн онцлогт тохирсон олон арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн, ахиц дэвшил гаргах замаар цар тахлын тархалтыг зогсоож, хяналтад авч байна.

Энэ хэсэгт зөвхөн цар тахлын аюулын эсрэг тэмцэхэд хязгаарлалтын дэглэм, цагдаагийн байгууллагын эрх, үүрэг болон иргэд, бизнесийн үйл ажиллагаанд тавигдаж буй хязгаарлалтын хууль эрх зүйн зохицуулалтыг тодруулах, сайн туршлага болгох үүднээс Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ), Англи Улсын жишээн дээр тулгуурлан дүн шинжилгээ хийв. Учир нь олон улсын цагдаагийн дарга нарын холбооноос цар тахлын улмаас цагдаа, хууль сахиулах байгууллага урьд өмнө байгаагүй сорилт, хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгааг онцлоод, энэ талаар олон арван мэдээллийн эх сурвалжийг толилуулснаас цар тахалтай тэмцэхэд цагдаагийн алба хаагчийн хууль сахиулах ажиллагаа нь илүү ойлгомжтой, мөн хууль сахиулах байгууллагад тодорхой эрх мэдлийг олгосон сайн туршлагаар Англи Улсыг нэрлэсэн болно.²⁷

Цар тахлын үед олон улсын цагдаагийн байгууллагын өмнө тулгарч буй бэрхшээл, сорилт, ололт амжилт нь тус тусын онцлогоор тодорхойлогдох боловч улс орнуудын цагдаагийн

²⁷ <https://www.theiacp.org/global-police-response-to-covid-19>

үйл ажиллагаанд ижил, төсөөтэй зүйл их байна. Судалгааны ажлын хүрээнд цар тахлын хязгаарлалтын дэглэм, цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийн хууль зүйн үндсийг авч үзэв. Учир нь иргэний ямар эрх, ямар нөхцөлд хэрхэн хязгаарлагдах, түүнчлэн цагдаагийн алба хаагч ямар хуулийг сахиулах ёстой вэ? гэдэг нь ил тод, ойлгомжтой байхын үндэс нь хууль, журмаас шууд шалтгаалж байгаа нь харагдаж байна.

Хязгаарлалтын дэглэм тогтоож хүний хөдөлгөөнийг хязгаарлахдаа албан тушаалтны үүрэг, даалгавраар биш, зөвхөн хуулиар зохицуулдаг болохыг судалгааны эх сурвалж тод гэрчилнэ. Тухайлбал, замын хөдөлгөөнд хязгаарлалт тогтооход хууль эсхүл хуулиар эрх олгогдсон албан тушаалтны гаргасан хуульчилсан актаар хэм хэмжээ тогтоож өгөх ба зөвхөн тухайн хэм хэмжээг сахиулах, мөрдүүлэх, зохицуулах үүргийг цагдаагийн байгууллага хийж гүйцэтгэж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож байна. Мөн хүн амын эрүүл мэндэд халдварт өвчний аюул нүүрлэхэд ямар хуулиар уг харилцааг зохицуулдаг болох, хүний эрхийн хязгаарлалтыг хуулиар хэрхэн тодорхой зохицуулдаг болохыг Англи Улсын жишээнээс харж болно.

ИБУИНВУ-ын засаг захиргаа, төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас халдварт өвчний үед зайлшгүй шаардлагын улмаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шийдвэр бүр нь хуульд бүрэн нийцсэн, хуулийн тодорхой хэм хэмжээнд үндэслэн гарсан байна. Нийгмийн амьдралыг хууль зохицуулах нь гарцаагүй бөгөөд хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийгдэх бол зөвхөн хуулиар хийгддэг.

ИБУИНВУ-ын коронавируст цар тахалтай тэмцэх чиглэлээр гаргасан хууль тогтоомж нь хэтэрхий их бөгөөд Нэгдсэн Вант Улсын хэмжээнд Европын холбооны хууль тогтоомжийг мөн дагаж мөрддөг тул судалгааны зорилгоос хэт давсан тайлбар болж цаг хугацаа их шаардана. Иймд зөвхөн Англи Улсын хувьд хууль болон хуульчилсан актаар дэглэм, хязгаарлалт тогтоож буйг түүвэрлэн авч судлав.

Англи Улсын хууль эрх зүйн тогтолцоо, ухамсар, соёл харьцангуй өндөр хөгжилтэй ч хууль дээдлэх, хүний эрхийг

зөвхөн хуулиар хязгаарлах эрх зүйн зарчим нэгэн адил гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой билээ. Англи Улсад коронавируст цар тахалтай тэмцэхэд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэн ажиллах, шийдвэр гаргах эрх зүйн гол эх сурвалж болох Коронавирустэй тэмцэх хууль (*Coronavirus Act 2020 (c.7)*) болон Нийтийн эрүүл мэндийн ба Өвчний хяналтын тухай хууль (*Public Health (Control of Disease) Act 1984 (c22)*) (*primary legislation*)²⁸ гол зохицуулалт болохын зэрэгцээ бусад чиглэлээр батлагдан гарч буй хуулиудын эрх сурвалж нь болж байна.

Коронавирустэй тэмцэх хууль 2020 оны 3 дугаар сарын 25-нд батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд маш олон төрлийн харилцааг зохицуулсан олон бүлэг, зүйл заалт бүхий хууль юм. Уг хууль нь цар тахлын аюул тус улсын хүн амын эрүүл мэндэд бодит аюул учруулж буй вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, тархалтыг хязгаарлах, эмчлэх зэрэг олон хариу арга хэмжээний улмаас нийгэм, эдийн засаг, банк санхүү даатгалын салбарт үүссэн өөрчлөлттэй холбоотой болон эрүүл мэндийн ажилтны нөөцийг бэлтгэх, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зузаатгахаас эхлээд шүүх хуулийн байгууллагад мөрдөн шалгах эрх мэдэл олгох, тэтгэвэр, тэтгэмж, түүнчлэн нутаг дэвсгэр засаг захиргааны удирдлагад эрх мэдэл олгох, хүн олноор цугладаг газар объектод тодорхой хязгаарлалт зохицуулалт хийх зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх харилцааг зохицуулах зорилготой байна.

ИБУИНВУ-ын хувьд Нийтийн эрүүл мэндийн тухай хууль болон Халдварт өвчний хяналтын тухай хуулиар аливаа халдварт өвчинтэй тэмцэх төрийн байгууллагын чиг үүрэг, эрх мэдэл,

²⁸ <http://www.legislation.gov.uk/coronavirus> Тайлбар: legislation нь үгийн утгаараа хууль тогтоох үйл ажиллагаа, ялангуяа бичмэл хууль боловсруулах, хийх, хууль батлах үйл гэсэн үндсэн утгатай; ИБУИНВУ- эрх зүйн системд бичмэл хууль, тус улсад Парламентаас батлан гаргасан хуульд хууль гаргах эрхийг олгосны дагуу ихэвчлэн салбарын сайдууд (өөр эрх бүхий субъект бий) гаргана. Энэ хууль нь Парламентаас батлан гаргасан primary legislation болох Act of Parliament-аар илүү нарийвчилсан зохицуулалт хэм хэмжээ эсхүл шинэ журам гаргана. Хууль хэрэгжүүлэх процесс давамгайл бичигдэнэ. Black’s Law Dictionary, Tenth Edition, Bryan A. Carner. West Publishing Co, 2004

үйл ажиллагааны журмыг нарийвчлан зохицуулсан хэдий ч коронавирусийн халдварт өвчний үед нэмэлт хуулиудыг тухай бүр батлан гаргаж байна.

Энэ хуулиар халдварын тархалтыг зогсоох, эмнэлгийн үйлчилгээнд хамруулах үүднээс коронавирусийн халдвартай хүнийг саатуулах, шалгах эрх мэдлийг цагдаагийн байгууллагад олгожээ.²⁹ Тус хуулийн 8.2 дахь хэсэгт хориглосон, хязгаарласан заалтыг зөрчсөн хүн болон хуулийн этгээдэд цагдаагийн ажилтан шаардлага мэдэгдэх хуудас (*prohibition notes*)³⁰ өгөх эрхтэй гэж заасан.

Хуулийн 8.3-т зөвхөн зайлшгүй шаардлага буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар эрүүл мэндийн тусламж авах, эмийн сан руу явах, амьдралын зайлшгүй хэрэгцээт зүйлсийг олж авах, халамж үйлчилгээ шаарддаг хүнийг асрах сувилахаар явах, биеийн тамирын дасгал хийх зорилгоор гэр, оршин сууж буй газраас гарахыг зөвшөөрчээ.

Харин олон нийтийн газар олон хүн нэг дор цуглах, тамхи татах зэргийг хориглож, тийм тохиолдолд цагдаа хүмүүсийг байгаа газраа орхин явахыг шаардах, үл биелүүлсэн тохиолдолд торгох эрхтэй байна.

Хуульд нэг гэр бүлийн гишүүд, мөн нэг гэрт амьдардаг болохоо нотолсон хүмүүс гарч хамтдаа салхилах, оршин суугаа газрын гадаа гарах, суух зэргийг хориглоогүй ба харин хоёроос дээш бусад (нэг гэр бүлийн биш, хамт нэг орон сууцанд амьдардаггүй) хүмүүс нэг дор цуглахыг хориглосон байна. Түүнчлэн кафе, ресторан, бар зэрэг барилга байгууламж дотор үйлчилгээ нь явагддаг газруудыг хаасан бол, автомашинтайгаа (*drive through*) хүнсний зүйлийг өөрсдөө авдаг танхимын бус үйлчилгээг зөвшөөрчээ.

²⁹ Police power буюу цагдаагийн эрх мэдэл нь иргэдийн эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, ямар үйлдлийг хориглож түүнийг цагдаа сахиулах, зөрчигдсөн тохиолдолд торгох,... эрүүгийн ял шийтгэл оногдуулахаар хуульчилснаар тодорхой болжээ. Хориглосон, хязгаарласан үйлдлүүд ямар тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаан болж зөвшөөрөгдөхийг хүртэл тусгасан.

³⁰ Английн Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлын тухай 1974 оны хуульд зааснаар хууль зөрчигдөж байгааг сануулах мэдэгдэх хуудас Oxford Dictionary of Law.

Тус хуулиар иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэхээс сэргийлэх, орлого амьжиргааг дэмжих зорилгоор, олон төрлийн нарийвчилсан, ухаалаг зохицуулалтыг хийжээ. Тухайлбал, жижиг дэн буудал, зочид буудал, дэлгүүрийг хаасан хэдий ч уг бизнесийг эрхэлж буй хүн нь тус ажлын байрандаа байнга оршин сууж амьдардаг, хэрэв дэлгүүр, зочид буудлыг нь хаавал өөр амьдрах газаргүй, эсхүл алслагдсан бүс нутагт байх өөрийн гэр рүүгээ зорчин явах шаардлага үүсэхээр бол хүндэтгэн үзэх шалтгаанд тооцож тухайн үйлчилгээг нээлттэй байхыг зөвшөөрсөн байна.

Мөн уг хуулийг зөрчсөн этгээдэд оногдуулах торгуулийг өндөр тогтоосон бөгөөд эхний зөрчлөөр торгуулсан этгээд 14 хоногт торгуулийг төлж барагдуулаагүй бол давтан үйлдэлд торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх замаар түүнийг *fixed penalty* горимоор 960 хүртэлх фунт стерлингээр торгох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шүүхээр хэлэлцэн хэргийг шийдвэрлэхээр хуульчилжээ.

Дээрх хуулиудаас гадна хуульд заасан эрх хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас цар тахалтай тэмцэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад шууд чиглэн гаргасан 200 гаруй хуулийг (*Secondary legislation*) дагаж мөрдөж байна. Тухайлбал, хүний зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулах (зам гудамж зорчих хэсгийг түр хугацаагаар хаах, чиглэлд өөрчлөлт оруулах), өмчийн бүх хэлбэр бүхий бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт, зохицуулалтыг хийх харилцааг зохицуулсан хуулиудыг гаргасан байна.

4.2. Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д коронавируст (COVID-19) цар тахлын анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн. Тус улсын хувьд цар тахалтай тэмцэх стратегийг “TRUST” хэмээн томъёолж, түүнийгээ үндэсний хэмжээнд уриа болгон дэвшүүлж, цар тахалтай тэмцэх ажлыг ил тод, шуурхай буюу вирусийн халдварын тохиолдол гарахыг хүлээлгүйгээр урьтаж түргэвчилсэн тестээр илрүүлэх, вирусийн халдвар авсан

хүнийг тусгаарлан ажиглах, эмчлэх нь зүйтэй гэсэн тактикаар ажилласан байна.

Эхний ээлжид түргэвчилсэн шинжилгээ авах иж бүрдлийг үйлдвэрлэх, бэлтгэх нөөцөд анхаарч төрийн ба хувийн хэвшлийн эмнэлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч болон эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх боломж бүхий бизнесийн төлөөллөөс багтсан үндэсний зөвлөл байгуулж ажилласан бөгөөд үүний үр дүнд халдварыг тархаж голомтлохоос өмнө илрүүлэх ажлыг яаралтай зохион байгуулж чаджээ. Зарим хотуудад өдөрт 20,000 хүртэл хүнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж ингэхдээ явуулын аргаар явган зорчигч, болон тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцож буй иргэдийг шинжилгээнд хамруулахад голчлон анхаарчээ.

Мөн тус улс урьд нь тохиолдож байсан халдварт өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлсэн ажлын туршлагад үндэслэн алдааг давтахгүйн тулд ялангуяа төрийн байгууллага хоорондын үл ойлголцол, хамтран ажиллахад саад болж байсан асуудлуудыг засаж, 2015 оноос хойш батлагдсан олон хууль тогтоомжид өөрчлөлт оруулсаар ирсэн байна. Тухайлбал, 2020 онд шинэ коронавирсийн халдварын тохиолдол илэрснээс хойш дараах хуулиудад нэмэлт оруулжээ. Үүнд:

- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хяналтын тухай (Infectious Disease Control and Prevention Act; /Act No. 9847, Dec. 29, 2009)
- Хорио цээрийн тухай (Quarantine Act /Act No.9846 Dec.29, 2009)
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тухай (Medical Service Act /Act No.8366 Apr.11,2007)

Халдварт өвчний төрөл, Солонгос Улсад бүртгэгдсэн болон бүртгэгдэх магадлалтай халдварт өвчнийг хуульчлан зааж, тэдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон бусад байгууллагын, түүнчлэн иргэдийн хүлээх үүргийг нарийвчлан тусгасан байна. Ялангуяа “COVID-19” цар тахалтай тэмцэхтэй холбогдуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хяналтын тухай хуулиудад нарийвчилсан зохицуулалтуудыг нэмжээ.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, тэмцэхтэй холбоотой хуулиар тогтоосон арга хэмжээг мөрдөж ажиллаагүй хүн, хуулийн этгээдэд захиргааны шийтгэл оногдуулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэж хорих ялаар шийтгэх хүртэл зүйл, заалтыг нэмж оруулсан байна.

БНСУ-ын цар тахалтай тэмцэх хуульд тухайн хуулийн аль зүйл заалтыг зөрчсөн бол ямар хариуцлага хүлээлгэхийг тодорхой тусгаж өгсөн нь уг хуулийг сахиулах, хэрэгжүүлэх ажлыг тодорхой болгожээ. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий ажилтан халдварт өвчнөөр өвчилсөн байх магадлалтай хүнийг шинжилгээ өгөхийг шаардахад эсэргүүцсэн бол 3 сая хүртэлх воноор (ойролцоогоор 2430 ам.доллар) торгох шийтгэл оногдуулна гэж заажээ.³¹

БНСУ-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуульд хүн амын эрүүл мэндийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй хуульчилж өгсөн байна. Ялангуяа эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам халдварт өвчин, цар тахал дэгдсэн үед хуульд заасан эрхийн хүрээнд аливаа шаардлагатай арга хэмжээ авахыг бусад байгууллагад даалгах, хамтарч ажиллах эрх зүйн үндэслэлүүдийг хуульчилж өгсөн нь онцлог байв.

Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, мөрдөх дэглэм горимыг нарийвчлан хуульчилсан нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхой болгосон сайн туршлага харагдаж байна.

³¹ [http://elaw.klri.re.kr/kor_service/lawView Infectious Disease Control and Prevention Act. \(Amended arts. 13 para. 2; 807 subpara.2-2\)](http://elaw.klri.re.kr/kor_service/lawView Infectious Disease Control and Prevention Act. (Amended arts. 13 para. 2; 807 subpara.2-2))

ДҮГНЭЛТ

1. Цар тахлын хуульд халдвараас урьдчилан сэргийлж хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцсэн хориглосон, хязгаарласан хэм хэмжээг тодорхой зааж өгөөгүй; эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй хориглосон, дэг горим тогтоосон нийтэд үйлчлэх шийдвэр (засаг даргын захирамж) нь тодорхой бус; уг шийдвэрийн хэрэгжилтийг хангах арга, зам болсон “хязгаарлалтын дэглэм” тогтоох журмыг батлан гаргахаар хуульчилсан боловч тэдгээр журам батлагдаж гараагүй байна.

Мөн хөл хорио, хорио цээрийн дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдал, хатуу хөл хорио, хязгаарлалтын дэглэм, бүх нийтийн хөл хорио гэх мэт олон үг хэллэг, ойлголт цаг үеийн шаардлагаар хэрэглэгдэж байгаагийн зэрэгцээ эрх бүхий албан тушаалтны шийдвэрүүдэд “хөл хорио”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм” зэрэг хуульчилсан үг хэллэг, нэр томъёог буруу хэрэглэж байна. Үр дүнд нь бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэд ямар эрх нь, хэдий хугацаанд, хэрхэн хязгаарлагдсан талаар үнэн бодитой мэдээлэл авч чадахгүй байх, мөн амьдралын зайлшгүй хүндэтгэн үзэх шаардлагаас үүдсэн зорчих хөдөлгөөнөө хийх боломжгүй болсон мэт төөрөгдөлд орох, хохирох нөхцөлд хүргэж байна. Эдгээр нөхцөл байдлууд нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль сахиулах ажиллагааг тодорхойгүй болгохын зэрэгцээ иргэд, цагдаагийн алба хаагчдын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

2. Санал асуулгад оролцогчдын 63.6 хувь нь ЗГ, УОК-оос гаргасан шийдвэрийг иргэд дагаж мөрдөхгүй байна, 30.8 хувь нь ЗГ, УОК-оос гаргасан шийдвэр нь иргэдийн амьдралын зайлшгүй хэрэгцээ, хувь хүний хүндэтгэн үзэх тохиолдлыг зохицуулж чадахгүй хүндрэл учруулж байна, 40.8 хувь нь иргэдийн харьцаа хандлага тааруу, тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байна, 64.5 хувь нь иргэд хэл амаар доромжилж цагдаагийн

алба хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцэж байна, 54.1 хувь нь (2 хүн тутмын 1 нь) амарч байгаа хугацаагаа өөрийн гэр бүлдээ зарцуулж чадахгүй байна гэж тус тус хариулсан нь дээр дурдсан дүгнэлтийг баталгаажуулахын зэрэгцээ цагдаа-иргэдийн харьцаа сайнгүй байгааг харуулж байна.

Гэвч цагдаагийн алба хаагчдын үүргийг хууль эрх зүйн хувьд тодорхой болгох нь иргэн, цагдаагийн алба хаагчийн харилцааг сайжруулах, итгэлцлийг өндөрсгөх дан ганц хүчин зүйл биш юм. Цаашид цагдаагийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвхөн олон нийтийн цагдааг ажиллуулах хэлбэрээр хязгаарлах бус, хүний эрхийг ойлгох, хууль сахиулах ажлын философи, ёс зүйг дээшлүүлэх, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн бодлогыг тууштай хэрэгжүүлж энэ талаар онолын болон практик сургалтыг үр дүнтэй зохион байгуулах нь ач холбогдолтой.

3. Манай улс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, тархсан үед ажиллах мэргэжлийн үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулсан, нийтээр хориглосон, хязгаарласан дэглэмийг тодорхойлсон, хууль хэрэгжих механизм болсон журмаа дотроо агуулсан, хуулиар хориглосон эсхүл бусдад үүрэг болгосон шинжтэй заалтууд нь тодорхой, зөрчсөн тохиолдолд шийтгэл хүлээлгэх заалттай, зөвхөн байгууллагын үйл ажиллагаанаас гадна шууд хамаарал бүхий олон талт харилцааг зохицуулсан тусгайлсан хууль батлан гаргах шаардлагатай гэж үзлээ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Коронавирусийн халдварын аюулаас урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох;
- Хүний эрхийг хөндөх хязгаарлалтын дэглэм шаардсан арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох;
- Хориглосон, хязгаарласан дэг, горим тогтоож байгаа шийдвэрийг хуулийн шаардлагад нийцүүлэн гаргах;
- Хуульд заасан журмуудыг батлан гаргаж мөрдүүлэх тухайлбал, Цар тахлын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1; 7.1.6; 7.1.17-д, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3; 8.1.4; 9 дүгээр зүйлийн 9.1; 9.2; 9.8; 9.9; 9.10; 9.11; 9.12-т, 16 дугаар зүйлийн 16.3-т болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмуудыг тус тус батлан гаргах, мөрдөж ажиллах;
- Амьдралын зайлшгүй хүндэтгэх үзэх шалтгаан, шийдэх арга замыг зохих журамд нарийвчлан тусгах;
- Хүний эрхийг хязгаарласан хязгаарлалтын дэглэмийг мөрдүүлэн сахиулах субъект, түүний үүрэг оролцоог тодорхой болгох;
- Хууль, журмыг хэрэгжүүлэх аргачилсан зааврыг баталж мөрдүүлэх;
- Шинээр баталсан хууль, журмыг иргэдэд таниулах, сурталчлах, даган биелүүлэхийг уриалах ажлыг тухай бүр зохион байгуулах;
- Цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд хуулиар иргэн, аж ахуйн нэгжид хүлээлгэсэн үүргийг идэвхтэй сурталчилж ойлгуулах;
- Иргэний эрхийг хүндэтгэж хүнлэг, ёс зүйтэй харьцаж, хууль сахиулах;

- Гамшгаас хамгаалах тухай болон “цар тахлын” хуулийн зорилтын хүрээнд гарч байгаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр, уг хуулиудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхтэй холбоотой зүйл, заалтын хэрэгжилтийг хангах, тухайлбал Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5, 49.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах;
- Цар тахлын хуулийн хэрэгжилтийг сар бүр нээлттэй хэлэлцүүлэх, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 58 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах.

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол Улсын хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он (Шинэчилсэн найруулга)
2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020 он
3. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он (Шинэчилсэн найруулга)
4. Онц байдлын тухай хууль, 1995 он
5. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он (Шинэчилсэн найруулга)
6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 он (Шинэчилсэн найруулга)
7. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он (Шинэчилсэн найруулга)
8. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
9. Авто тээврийн тухай хууль, 1999 он
10. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 2000 он (Шинэчилсэн найруулга)
11. Зөрчлийн тухай хууль, 2017 он (Шинэчилсэн найруулга)
12. Эрүүгийн хууль, 2015 он (Шинэчилсэн найруулга)

Хоёр. Ном, сурах бичиг

1. Н.Лүндэндорж, “Төрийн онол”, 2020 он, УБ хот
2. Ш.Цогтоо, “Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй”, 2019 он, УБ хот
3. Ш.Цогтоо, “Захиргааны эрх зүй-Тусгай анги”, 2015 он, УБ хот
4. М.Батсуурь, Ч.Өнөрбаяр, “Эрх зүйт ёс”, 2011 он, УБ хот
5. Jonathan Law, “A Dictionary of Law”, 2018, Oxford University Press
6. Graham Gooch, Michael Williams, “A Dictionary of Law Enforcement”, 2007 Oxford University Press
7. Jack R. Greene, “The Encyclopedia of Police Science-Volume 1,2”, 2007, USA-NY

Гурав. Интернэт орчин дахь эх сурвалж

1. <https://www.legalinfo.mn/>
2. <https://nema.gov.mn/>
3. <https://zasag.mn/>
4. <http://parliament.mn/>
5. <https://ulaanbaatar.mn/Home/Rulelist?categID=15>
6. <https://www.un.org/en/coronavirus/covid-and-rule-law-dangerous-balancing-act>
7. <https://www.sidley.com/en/insights/newsupdates/2020/03/covid-19-control-measures--uk-police-powers>
8. <https://www.devex.com/news/policing-in-a-pandemic-law-matters-in-the-covid-19-response-97691>
9. <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/community/guidance-law-enforcement.html>

10. https://covid19.ncdc.gov.ng/media/files/COVID_19_BOOKLET_.pdf.pdf
11. https://www.theworldlawgroup.com/writable/documents/news/COVID-19_vol3.pdf
12. <https://www.tokyoreview.net/2020/05/covid-19-collective-action-and-japans-constitution/>
13. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/japan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
14. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/south-korea-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
15. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/russia-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
16. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/russia-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
17. <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/germany-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
18. <https://www.theiacp.org/global-police-response-to-covid-19>
19. <https://www.afpa.org.au/wp-content/uploads/2020/03/PFA-Letter-to-Members.pdf>
20. <https://www.interpol.int/en/News-and-Events/News/2020/INTERPOL-issues-international-guidelines-to-support-law-enforcement-response-to-COVID-19>
21. https://www.lexisnexis.com.au/en/COVID19_NZ/blogs-and-articles/the-legal-basis-for-the-lockdown-may-not-be-as-solid-as-weve-been-led-to-believe
22. <https://www.lewissilkin.com/en/insights/emergency-lockdown-legislation-published>
23. <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8875/>
24. <https://www.33bedfordrow.co.uk/insights/news/lockdown-becomes-law>
25. <https://www.theregreview.org/tag/covid-19/>
26. <https://www.dw.com/en/coronavirus-can-german-courts-overturn-all-lockdown-measures/a-55477209>
27. <https://verfassungsblog.de/fighting-covid-19-legal-powers-and-risks-south-korea/>
28. https://www.theworldlawgroup.com/writable/documents/news/COVID-19_vol3.pdf

Дөрөв. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр

№	Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
1	Ерөнхий сайд	1/26/2020	Засгийн газрын тогтоол №30	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д заасныг	шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
2	Ерөнхий сайд	1/31/2020	Засгийн газрын тогтоол №39	Тогтоол	Монгол Улсын Хилийн тухай хуулийн 21.2, 28.2-т заасныг	хилийн зарим боомтыг түр хаах нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай
3	Ерөнхийлөгч	2/12/2020	Ерөнхийлөгчийн зарлиг-10	Зарлиг	МУ-ын Үндсэн хуулийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, МУ-ын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, УАБЗ-ийн 2020.02.12 өдрийн 07/05 дугаар зөвлөмж	
4	Ерөнхий сайд	2/12/2020	Засгийн газрын тогтоол №62	Тогтоол	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.2, 11.3.3-т заасныг	бэлэн байдлын зэрэгт шилжих тухай

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
5	УОК-ын дарга, Шадар сайд 2/13/2020	УОК-ын даргын тушаал-4	Тушаал	ЗГ-ын 2020.02.12 өдрийн №62 тогтоолын 4 заалт	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж батлах тухай
6	Ерөнхий сайд 2/19/2020	Засгийн газрын тогтоол №64	Тогтоол	Монгол Улсын Хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3-г заасныг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
7	УОК-ын дарга, Шадар сайд 2/26/2020	УОК-ын тогтоол-2	Тогтоол	ЗГ-ын 2020.02.26 өдрийн хуралдаан, УОК-ын 7-р хурлын шийдвэр	Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай
8	УОК-ын дарга, Шадар сайд 3/1/2020	УОК-ын тогтоол-3	Тогтоол	УОК-ын ажиллах журмын 1.6, УОК-ын 8-р хурлын шийдвэр	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай
9	УОК-ын дарга, Шадар сайд 3/8/2020	УОК-ын тогтоол-4	Тогтоол	УОК-ын 9-р хурлын шийдвэр	Коронавирус халдвараас у/с зарим арга хэмжээний тухай
10	УОК-ын дарга, Шадар сайд 3/10/2020	УОК-ын тогтоол-5	Тогтоол	УОК-ын 10-р хурлын шийдвэр	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай
11	УОК-ын дарга, Шадар сайд 3/10/2020	УОК-ын тогтоол-6	Тогтоол	УОК-ын 11-р хурлын шийдвэр	Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай

12	Ерөнхий сайд	3/13/2020	Засгийн газрын тогтоол №63	Тогтоол	Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2-г заасныг	бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
13	Ерөнхий сайд	3/18/2020	Засгийн газрын тогтоол №98	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 5.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18.1, 18.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 17.2, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.7-д заасныг	эрүүл мэндийн сургалт эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай
14	Ерөнхий сайд	3/19/2020	Засгийн газрын тогтоол №101	Тогтоол	Олон улсад шинэ коронавирус (Covid-19)-ийн халдвар дэгдсэний улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хилийн хязгаарлалт тавьсантай холбогдуулан ноолуурын салбарыг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5, 13 дугаар зүйлийн 7, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 21.1.1, 21.2-г заасныг	ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
15	3/22/2020	Засгийн газрын тогтоол №102	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
16	3/27/2020	Засгийн газрын тогтоол №114	Тогтоол	Төсвийн тухай хуулийн 42.2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17-д заасныг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай
17	3/30/2020	УОК-ын тогтоол-7	Тогтоол	ЗГ-ын 2020 оны №102 тогтоолын 1 заалт	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай
18	3/30/2020	Захирамж-А(436)	Захирамж	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. в, 29.1.6. ж, л, 29.2, Архидан согуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2020 оны 30, 64, 102 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 07 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг	Коронавируст (Ковид - 19) халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг өрчимжүүлэх тухай

19	УОК-ын дарга, Шадар сайд	4/9/2020	УОК-ын тогтоол-8	Тогтоол	УОК-ын 15-р хурлын шийдвэр	2020 оны цэрэг таглагагай холбогдуулах авах арга хэмжээний тухай
20	УИХ-ын дарга	4/9/2020	УИХ-ын тогтоол №21	Тогтоол	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүд мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай
21	УОК-ын дарга, Шадар сайд	4/11/2020	УОК-ын тогтоол-9	Тогтоол	УОК-ын 16-р хурлын шийдвэр	Маскаа зүүцгээе аян өрнүүлэх тухай
22	Ерөнхий сайд	4/15/2020	Засгийн газрын тогтоол №126	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Коронавируст халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.12, 7.1.22, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг	тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолд

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
23	4/15/2020	Засгийн газрын тогтоол №132	Тогтоол	2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг	жагсаалт багтах тухай гааль неат-аас чөлөөлөх оношлуур эм эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмж ариутгал халдваргүйжүүлэлтийг бодис
24	4/15/2020	Засгийн газрын тогтоол №139	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг	Коронавируст халдвар (сovid-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
25	4/21/2020	УОК-ын тогтоол-10	Тогтоол	УОК-ын 19-р хурлын шийдвэр	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох тухай
26	4/29/2020	УИХ-ын тогтоол №31	Тогтоол	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дөгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг	Хуулийн төсөл буцаах тухай
27	4/29/2020	УИХ-ын тогтоол №32	Тогтоол	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг	Коронавируст халдвар (Ковид - 19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай

28	Ерөнхий сайд	4/29/2020	Засгийн газрын тогтоол №147	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зөрөгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
29	УОК-ын дарга, Шадар сайд	5/5/2020	УОК-ын тогтоол-11	Тогтоол	ЗГ-ын 2020 оны №102 тогтоолын 1 заалт	Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
30	Ерөнхий сайд	5/6/2020	Засгийн газрын тогтоол №164	Тогтоол	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3, 9.5-д заасныг	хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай
31	Ерөнхий сайд	5/6/2020	Засгийн газрын тогтоол №166	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг	тогтоолд өөрчлөлт оруулах тухай засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоолд
32	Ерөнхий сайд	5/6/2020	Засгийн газрын тогтоол №167	Тогтоол	Коронавируст халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 3 дахь хэсгийн 3-т заасныг	Коронавируст халдвар (сovid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай
33	Ерөнхий сайд	5/6/2020	Засгийн газрын тогтоол №168	Тогтоол	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2-г заасныг	Коронавируст халдвар (сovid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай
34	УИХ-ын дарга	5/15/2020	УИХ-ын тогтоол №58	Тогтоол	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
35	5/27/2020	Засгийн газрын тогтоол №188	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3.2, 7.1.24, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам багтах тухай
36	5/27/2020	Засгийн газрын тогтоол №195	Тогтоол	Боловсролын тухай хуулийн 40.2, Коронавируст халдвар (КОВИД-19)ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2, 7.1.9-д заасныг	терийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн боловсрол сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай
37	6/12/2020	Засгийн газрын тогтоол №213	Тогтоол	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-г заасныг	хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тухай
38	6/30/2020	Засгийн газрын тогтоол №234	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

39	Нийслэлийн засаг дарга	6/30/2020	Захирамж-А(930)	Захирамж	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. в, 29.1.6. г, ж, л, 29.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 92 дугаар захирамж, Улсын Онцгой комиссын 2020 оны 24, 25 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хурлын тэмдэглэлийг	"Коронавируст (Ковид - 19) цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай
40	Ерөнхий сайд	7/10/2020	Засгийн газрын тогтоол №1	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын санал	бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай
41	Ерөнхий сайд	7/29/2020	Засгийн газрын тогтоол №31	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын санал	бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай
42	Ерөнхий сайд	7/29/2020	Засгийн газрын тогтоол №32	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15.1, Улсын онцгой комиссын саналыг	боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай
43	УОК-ын дарга, Шадар сайд	8/7/2020	УОК-ын албан даалгавар-2	Албан даалгавар		

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
44 Ерөнхий сайд	8/12/2020	Засгийн газрын тогтоол №46	Тогтоол	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.6-д заасныг	тогтоолд өөрчлөлт оруулах тухай засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолд
45 Ерөнхий сайд	8/25/2020	Засгийн газрын тогтоол №70	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
46 ЦЕГ-дарга, ХХЗХ дарга	8/27/2020	Журам батлах тухай хамтарсан тушаал А(200) А(169)	Тушаал	Коронавируст халдвар (Ковид - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, Харилцаа, холбооны зохицуулах хорооны дүрмийн 3.1.2 дахь хэсгийг	Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам батлах тухай

47	Ерөнхий сайд	9/14/2020	Засгийн газрын тогтоол №103	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (Ковид - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зөрөгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
48	Ерөнхий сайд	9/30/2020	Засгийн газрын тогтоол №123	Тогтоол	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-г заасныг	гадаадаас 2021 онд авах ажиллах хүч мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай
49	Ерөнхий сайд	9/30/2020	Засгийн газрын тогтоол №124	Тогтоол	Коронавируст халдвар (КОВИД-19)ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.24, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1-д заасныг	журам батлах хөрөнгө гаргах тухай
50	УОК-ын дарга, Шадар сайд	10/19/2020	УОК-ын албан даалгавар-4	Албан даалгавар		

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
51 Ерөнхий сайд	10/28/2020	Засгийн газрын тогтоол №159	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (КОВИД-19)ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг	бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
52 УИХ-ын дарга	10/29/2020	УИХ-ын тогтоол №31	Тогтоол	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Коронавируст халдвар (Ковид - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг	Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн багтах тухай

53	Ерөнхий сайд	10/30/2020	Засгийн газрын тогтоол №164	Тогтоол	Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг	хилийн зарим боомтыг түр хаах нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох тухай
54	Ерөнхий сайд	11/4/2020	Засгийн газрын тогтоол №171	Тогтоол	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.7-д заасныг	халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай
55	УОК-ын дарга, Шадар сайд	11/11/2020	УОК-ын даргын тушаал-20	Тушаал	ЗГ-ын 2020.11.11 өдрийн №178 тогтоолын 2 заалт	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж батлах тухай
56	УОК-ын дарга, Шадар сайд	11/11/2020	УОК-ын тогтоол-12	Тогтоол	УОК-ын 33-р хурлын тэмдэглэл	Зорчигч тээврийн хэрэгслийн гарах хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалт, үзвэр үйлчилгээ, ахим болон хүүхдийн тоглоомын төвүүдийн үйл ажиллагааг түр зогсоох тухай

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
57	11/11/2020	Засгийн газрын тогтоол №172	Тогтоол	Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг	хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай
58	11/11/2020	Засгийн газрын тогтоол №178	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3 дахь заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 26/16 дугаар зөвлөмж, Эрсдэлийн үнэлгээний 14 дүгээр зөвлөмжийг	бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

59	Нийслэлийн засаг дарга	11/11/2020	Захирамж-А(1241)	Захирамж	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."в", 29.1.6."ж", "л", 29.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийг	"Коронавируст (Ковид - 19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай
60	Нийслэлийн засаг дарга	11/12/2020	Захирамж-А(1242)	Захирамж	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэлийг	"Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
61	УОК-ын дарга, Шадар сайд	11/13/2020	УОК-ын албан даалгавар-5	Албан даалгавар		

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан №	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
62	11/15/2020	Засгийн газрын тогтоол №181	Тогтоол	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2 дахь заалт, Улсын онцгой комиссын саналыг	бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай
63	11/18/2020	Засгийн газрын тогтоол №182	Тогтоол	Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг	хилийн боомтыг түр хаах нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох тухай
64	11/18/2020	Засгийн газрын тогтоол №183	Тогтоол	Коронавируст халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Тагварын ерөнхий хуулийн 55.2.7, 56.1-д заасныг	бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнгүй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

65	Нийслэлийн засаг дарга,	11/18/2020	Захирамж-А(1248)	Захирамж	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34, 35 дугаар хурлын тэмдэглэл, Улсын Онцгой комиссын Шуурхай Ажлын хэсгийн 6 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэлийг	Захирамжид өөрчлөлт оруулах тухай
66	Ерөнхий сайд	11/23/2020	Засгийн газрын тогтоол №187	Тогтоол	Төсвийн тухай хуулийн 42.2, Коронавирус халдвар (КОВИД - 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2-т заасныг	төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай

Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан	Огноо	Шийдвэрийн дугаар	Бичиг баримтын нэр	Эрх зүйн үндэслэл	Шийдвэрийн утга
67 Шадар сайд	11/25/2020	Тушаал-146	Тушаал	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 23 дугаар зүйлийн 23.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.6, 43 дугаар зүйлийн 43.2.3, 44 дүгээр зүйлийн 44.1.5, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 416, 2020 оны 178,181 дүгээр ТОГТООЛЫГ	Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам батлах тухай

ХАВСРАЛТ 1

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ САХИУЛАХ, ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХОД ЧИГЛЭСЭН АЛБА ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮН


2020 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Судалгааны ажлын зорилго, зорилтыг хангахаар нийт 24 асуулт бүхий санал асуулгын хуудсыг боловсруулж өгөгдлийг [google.form.doc](https://www.google.com/forms)-д оруулан 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн 9 хоногийн хугацаанд санал асуулгыг явуулж, дүнг 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэгтгэн гаргасан.

НЭГ: АНКЕТЫН ХЭСЭГ


Санал асуулгад аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагын 8 алба, нэгжийн нийт 1065 алба хаагч хамрагдсан байна. Үүнд:



- Захиргааны удирдлага – нийт 95 алба хаагч буюу 8,9 хувь
- Эрүүгийн цагдаагийн алба – нийт 134 алба хаагч буюу 12,6 хувь
- Мөрдөн байцаах алба – нийт 97 алба хаагч буюу 9,1 хувь
- Нийтийн хэв журам хамгаалах алба - нийт 504 алба хаагч буюу 47,3 хувь
- Тээврийн цагдаагийн алба - нийт 53 алба хаагч буюу 5 хувь
- Санхүү, аж ахуйн алба - нийт 8 алба хаагч буюу 0,8 хувь
- Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба - нийт 138 алба хаагч буюу 13 хувь
- Дотоодын цэргийн штаб - нийт 36 алба хаагч буюу 3,4 хувь тус тус хамралттай байна.

Судалгаанд хамрагдсан нийт 1065 алба хаагчаас 926 алба хаагч буюу 86,9 хувь нь эрэгтэй алба хаагч, 139 алба хаагч буюу 13,1 хувь нь эмэгтэй алба хаагч байх ба эрэгтэй алба хаагч 6 дахин илүү хамралттай байгаа нь хүн амын хүйсийн харьцааны хувьд харьцангуй ялгаатай боловч албаны онцлогийн хувьд нийцтэй байна.

Диаграм № 1 Хүйс




Насны хувьд судалгаанд хамрагдсан 1065 алба хаагч 100 хувь хариулт өгсөн байна. Үүнд хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Насны ангилал

	Frequency	Percent	
Valid	18-24 нас	140	13
	25-29 нас	302	28,4
	30-34 нас	339	31,8
	35-39 нас	170	16
	40-44 нас	89	8,4
	45-49 нас	20	1,9
	50-аас дээш нас	5	0,5
Total	1065	100,0	

Албанд ажилласан жилийг тодруулах асуулгад 1065 алба хаагч сонголтыг хийж, үүнээс нийт 99 алба хаагч буюу 9,3 хувь нь 1 хүртэлх жил, 231 алба хаагч буюу 21,7 хувь нь 1-3 жил, 173 алба хаагч буюу 16,2 хувь нь 4-6 жил, 173 алба хаагч буюу 16,2 хувь нь 7-10 жил, 229 алба хаагч буюу 21,5 хувь нь 11-15 жил, 127 алба хаагч буюу 11,9 хувь нь 16-20 жил, 33 алба хаагч буюу 3,1 хувь нь 21-ээс дээш жил байх ба 1-3 жил болон 11-15 жил ажилласан алба хаагчид дийлэнх хувийг эзэлсэн байна.

Диаграм № 1 Ажилласан жил




Хүснэгт № 2. Албанд ажилласан жил

	Frequency	Percent	
Valid	1 хүртэл	99	9,3
	1-3 жил	231	21,7
	4-6 жил	173	16,2
	7-10 жил	173	16,2
	11-15 жил	229	21,5
	16-20 жил	127	11,9
	20-оос дээш жил	33	3,1
Total	1065	100,0	

Албан тушаалын ангиллын хувьд нийт 1065 алба хаагчийн 99,4 хувь нь хариулт өгсөн ба 512 алба хаагч буюу 48,3 хувь офицер, 547 алба хаагч буюу 51,7 хувь нь ахлагч бүрэлдэхүүн хамрагдсан болохыг тодотгон сонголт хийжээ.

*Диаграм № 2. Албан тушаал *Цолоор*




Судалгаанд нийт 1059 алба хаагч хамрагдсанаас албан тушаалын ангиллаар авч үзвэл хамгийн их буюу цолны хувьд харьцангуй ижил түвшинд буюу 48,3х51,7 хувь офицер, ахлагч бүрэлдэхүүн оролцсон байна.

ХОЁР: АЖИЛ-ГЭР ХАРЬЦААНЫ ТЭНЦВЭРЖИЛТ


Асуулт 1. Алба хаагч та өдөрт хэдэн цаг ажиллаж байна вэ? гэсэн асуултад нийт 1065 алба хаагч хариулт өгснөөс тус бүр хувиар дараах сонголтыг хийсэн байна. Үүнээс 8-10 цаг гэж 308 алба хаагч буюу 28,9 хувь нь, 12-14 цаг гэж 414 алба хаагч буюу 38,9 хувь нь, 16-аас дээш цаг гэж 343 алба буюу 32,2 хувь нь тус бүр өөрсдийн ажлын цаг, ачааллыг тодорхойлсон. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 71,1 хувь нь буюу (3 хүн тутмын 2) нь 12 дээш цагаар ажиллаж байна.

Диаграм № 3. Ажлын цаг



Асуулт 1.1. Алба хаагч та өдөрт хэдэн цаг амарч байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь дараах хариултыг өгсөн. Үүнд, 8-10 цаг гэж 687 алба хаагч буюу 64,5 хувь нь, 10-14 цаг гэж 152 алба хаагч буюу 14,3 хувь нь, 15-аас дээш цаг гэж 82 алба хаагч буюу 7,7 хувь нь зорилтот хувилбараас сонголт хийж хариулсан бол, 5-7 хүртэлх цаг амардаг гэж 144 алба хаагч буюу 13,5 хувь нэмэлтээр өөрсдийн амралтын цагийг тодорхойлсон. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 64,5 хувь нь 8-10 цаг амарч байна.

Диаграм №4. Амралтын цаг




Асуулт 2. Та амарч байгаа хугацаагаа өөрийн гэр бүлдээ зориулж чадаж байна уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 99,1 хувь нь буюу 1055 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Тийм гэж 484 алба хаагч буюу 45,9 хувь нь, Үгүй гэж 571 алба хаагч буюу 54,1 хувь нь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 54,1 хувь нь (2 хүн тутмын 1 нь) гэр бүлдээ цаг зарцуулж чаддаггүй байна.

Диаграм №5. Гэр бүлд зарцуулах цаг




Асуулт 3. Та Коронавируст халдварт өвчний талаарх ойлголт хэр байгаа вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Ойлголт байгаа гэж 1048 алба хаагч буюу 98,4 хувь нь, Ойлголт байхгүй гэж 5 алба хаагч буюу 0,5 хувь нь, Мэдэхгүй гэж 12 алба хаагч буюу 1,1 хувь нь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 98,4 хувь нь Коронавируст халдварт өвчний талаарх ойлголттой байна.

Диаграм №6. Коронавируст халдварын талаарх ойлголт




Асуулт 4. Бүх нийтийн бэлэн байдлын үед цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн хэрэгжүүлэх чиг үүргийг ойлгож, мэдэж байгаа эсэх? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Тийм гэж 1053 алба хаагч буюу 98,9 хувь нь, Үгүй гэж 12 алба хаагч буюу 1,1 хувь нь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 98,9 хувь нь бүх нийтийн бэлэн байдлын үед цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн хэрэгжүүлэх чиг үүргийг ойлгож, мэдэж байна.

Диаграм №7. Хэрэгжүүлэх чиг үүргийн ойлголт



Асуулт 5. Та одоо үүрэг гүйцэтгэхдээ ямар хууль эрх зүйн актыг баримталж байгаа вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Ердийн үед мөрддөг хууль эрх зүйн акт гэж 41 алба хаагч буюу 3,8 хувь нь, Коронавируст халдвар, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль гэж 145 алба хаагч буюу 13,6 хувь нь, Засгийн газар, Улсын онцгой комисс, Улсын их хурлын шийдвэр гэж 434 алба хаагч буюу 41,2 хувь нь, Шууд удирдлагаас өгсөн шийдвэр гэж 440 алба хаагч буюу 41,3 хувь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 82,5 хувь нь Засгийн газар, Улсын онцгой комисс, Улсын их хурлын шийдвэрийн хүрээнд шууд удирдлагаас өгсөн шийдвэрийг хэрэгжүүлж байна гэж тодорхойлсон байна.

Диаграм №8. Баримтлан ажиллаж буй хууль эрх зүйн акт




Асуулт 6. Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэл / аймаг/-ийн онцгой комиссоос гаргаж буй шийдвэр, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн талаарх болон мэргэжлийн бусад байгууллагаас гаргаж буй зөвлөмж, анхааруулга, сэрэмжлүүлгийн талаарх мэдээллийг хэрхэн авч байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь нь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнээс 50 хувь нь дээрх нэн шаардлагатай мэдээ мэдээллийг байгууллага, удирдлагаас авч байгаа хэмээн хариулжээ.

Хүснэгт №3. Мэдээлэл авч буй эх сурвалж

	Frequency	Percent
Зурагтаар	867	34,5
Ар гэрийнхнээс	47	4,4
Хамт ажилладаг хүмүүсээс	88	8,3
Valid Иргэдээс	4	0,4
Бусад байгууллагын ажилтнуудаас /онцгой, эмнэлэг/	27	2,5
Байгууллага, удирдлагаас	532	50
Total	1065	100,0

Диаграм №9. Мэдээлэл авч буй эх сурвалж



Асуулт 7. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэл /аймаг/-ийн онцгой комиссоос гаргаж буй шийдвэр нь ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байна уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь нь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Тийм гэж 862 алба хаагч буюу 80,9 хувь нь, Үгүй гэж 203 алба хаагч буюу 19,1 хувь нь хариултын хувилбараас сонголт хийсэн. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 80,9 хувь нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэл /аймаг/-ийн онцгой комиссоос гаргаж буй шийдвэр нь ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байна гэж үзжээ.

Диаграм №10 Дээд шатны байгууллагаас гаргаж буй шийдвэрийг хэрэгжүүлэх боломж



Асуулт 7.1. Хэрвээ ойлгомжгүй эсвэл хэрэгжүүлэн ажиллахад тулгарч буй бэрхшээл байгаа бол та нээлттэйгээр санал сэтгэгдлээ илэрхийлнэ үү? гэсэн асуултад 34,3 хувь дараах байдлаар хариултыг өгсөн байна. Түүврийг танилцуулбал:

- иргэдийн хэнэггүй зан
- байгууллагаас ямар чиглэл ирнэ түүнийг хэрэгжүүлж ажиллах
- хүн хүч хүрэлцэхгүй
- тийм
- зарим талд нь давуу эрх олгож байгаа мэт харагдаж байна
- зарим шийдвэр сөрөг үр дагавар гаргаж болзошгүй байна
- тодорхойгүй
- гаргасан шийдвэр, захирамж тодорхой бус, хоорондоо харилцан уялдаа холбоо муутай байна.
- цагдаагийн гүйцэтгэх ажлыг илүү тодорхой болгох, ихэнх ажлаа цагдаагаар хийлгэх гээд байдаг байдлыг таслан зогсоох
- гаргаж байгаа шийдвэр нь тодорхойгүй байна
- тодорхой бус
- тусгаарлалтад байлгах иргэдийг ямар дэглэмээр хэрхэн яаж байлгах талаар онцгой комисс тодорхой чиглэлгүй байна. Зөвхөн хотоос орж ирж байгаа хүмүүсийг гэрийн тусгаарлалтад байлга гэж байна. Тэдгээр хүмүүсийн ар гэр нь энэ талаар ямар ч ойлголт алга. Онцгой комисс зөвшөөрлийн хуудас хэт их хавтгайруулан олгоод байна.
- байгууллагуудын хоорондын уялдаа холбоо
- уялдаа муутай. Зарим шийдвэрүүд тийм ч оновчтой биш байна
- шийдвэрээ оновчтой гаргамаар байна
- алба хаагчдын аюулгүй байдал хамгаалалтын хувцас хангамж
- зарим зүйл дээр санал нийлэхгүй байгаа
- ямар ч дэг журам байхгүй
- гэрийн хорионд байгаа иргэдийн гэр бүлийн гишүүд нь өдөр тутмын хөдөлгөөнд чөлөөтэй оролцож байгаа нь эрсдэлтэй байна.
- хувь хүний машины хөдөлгөөн хаах
- гаргаж байгаа шийдвэрүүдээ тодорхой шийдэлд хүргэж гаргах, зарим шийдвэрүүд ойлгомжгүй байна иргэдэд мэдээ мэдээллийг сайн түгээх
- шийдвэрүүд нь байнга өөрчлөгдөж, хоорондоо зөрчилдөж байна
- иргэдэд сайн сурталчилж ойлгуулах
- орон нутгаас ирж буй иргэдийг тухайн газраас нь явуулахгүй арга хэмжээ авахгүй бол хотын захад орох газаргүй хүндрэлтэй байна
- иргэд тавьсан шаардлагыг эсэргүүцэх
- алба хаагчдад иргэдийн хөл хөдөлгөөнийг багасгахад хариуцлага тооцох эрх олгох
- тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, зорчих зөвшөөрөл хэрхэн авах талаар ойлголтгүй
- тийм ч боломжтой биш
- олон дахин өөрчлөгдөж байна.
- Зарим ААН нээгдсэн нь хорио цээрийн дэглэм алдагдуулж байна
- хатуу хөл хорио гэсэн мөртөө банкнууд зах худалдааны төвүүд

- ажиллаж байгаа учраас иргэд явсаар л цагдаагийн шаардлага ч биелүүлэх нь муу, ийм цед гудамж талбайд олон цагаар цагдаагийн алба хаагчийг зогсоогоод хэрэгтэй юмуу гэсэн бодол төрдөг
- 10 цагт хол хорио тогтоосон цед хэнийг ч явуулахгүй гэдэг, тухайн цагт томоохон дэлгүүр, захыг хаалгах хэрэгтэй байна.
 - эргэж буцсан шийдвэрүүд гаргаж байна
 - Архангайд идшээ пост дээр солилцож байгаа гэж ялгаагүй хоорондоо харьцаж байна
 - тодорхой тогтсон мэдээлэл ховор байна.
 - Явган эргүүлийн цаг хэт урт, даарч байна
 - хөрсөн дээр буусан ажил үйлчилгээг авч хэрэгжүүлэхгүй, бараа бүтээгдэхүүний гэх мэт.
 - УОК, НОК гаргаж буй шийдвэрүүд ойлгомжгүй байна
 - УОК, НОК -оос гаргаж байгаа шийдвэр оновчтой бус өдөр өдөр өөр байна, хатуу хөл хорио гэсэн боловч иргэдийг зорчих нөхцөлийг бүрдүүлж үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад хүндрэл учирч байна
 - УОК, НОК -оос гаргаж байгаа шийдвэр ойлгомжгүй, оновчтой биш байна.
 - хаана шинжилгээ өгөх, хариугаа хэрхэн авах, хөдөө орон нутаг руу хэрхэн явах талаар ойлгомжтой ярих
 - нийтийн тээвэр болон худалдаа үйлчилгээний байгууллагаа нээхээд хөл хорио тогтооно гэдэг боломжгүй мэт санагдсан
 - хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр гаргаад алба хаагчаар хийлгүүлэхийг шаарддаг
 - эргүүлийн цагийг багасгах, гадаа хүйтэнд удаан ажиллуулж байна
 - гаргасан шийдвэр нь эргэж буцсан иргэдийг их бухимдуулж байна үүнээс үүдэн иргэд цагдаагийн алба хаагчидтай үл ойлголцох тавьсан шаардлагыг нь эсэргүүцэж, хэл үгээр доромжлох асуудал гарч байна.
 - халдвар авах эрсдэлтэй, мөн хамгаалах хувцас байхгүй байна
 - хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд ойлгомжтой мэдээлэл өгдөггүй, энэ байдлаас болоод иргэн цагдаа хоёрын дунд зөрчил үүсдэг.
 - олон бэрхшээл байна шүү дээ
 - гудамжинд явган хүний тоо ихсэж байна
 - 1 юм олон дахин давтамжтай байна
 - бэрхшээл байхгүй
 - автобус явуулсан мөртөө, машинд хориг тавьсан талаар ойлгохгүй байна.
 - гаргаж буй шийдвэрүүд уялдаа холбоо байхгүй
 - хэрэгжүүлж ажиллахад ойлгомжтой
 - эргэж буцсан шийдвэрүүдийг хэрэгжүүлж иргэдэд шаардлага тавихад үл ойлголцол үүсэж байна
 - онцгой комиссын шийдвэр эргэлзээтэй гардаг.
 - автобусны хөдөлгөөнийг хориглох
 - УОК гаргаж байгаа шийдвэр амьдрал дээр, газар дээр хэрэгжихгүй байна. Нийгэмд тухайн нөхцөл байдалдаа тааруулж, шийдвэр нь оновчтой гарахгүй байна.
 - зарим талаар бөөрөнхий шийдвэр гардаг

- хэт олон дарга нар байна. Иймд шууд удирдах даргын шийдвэрээр ажиллаж байгаа
- хамгаалалтын хувцсаар сайтар хангах
- гаргаж буй шийдвэр ойлгомжгүй
- иргэдэд хүрч байгаа мэдээлэл ойлгомжгүй байна
- албанд авто машин шаардлагатай байна
- иргэдийн хөдөлгөөн их байгаа
- нэгдсэн ойлголт алга
- зарим алба хаагчид илүү цагаар ажиллаж байгаа
- халдвар тарж байгааг анхаарахгүй хумьж чадахгүй байна.
- ойлгомжгүй
- алба хаагчдын ар гэрийн асуудал хүнд байна. Эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа учир ар гэрийнхээс дарамт ирэх, түүнээс болоод ажилдаа хандах хандлага сулрах зэрэг асуудал байна.
- алба хаагчдад урамшууллыг нь ялгаваргүй олгуулах
- олон өөрчлөгдөж байна
- илүү цагийн урамшуулал олгох
- шийдвэр амьдралд нийцгүй олон талт, салаа утгатай
- хамгаалалтын хэрэгсэл
- аймгаас гарах хөдөлгөөнд зөвхөн цагдаагаас бичиг өгч баймаар байна, багийн дарга нар бүх хүнд өгөөд байна
- тулгарч буй бэрхшээл байхгүй
- хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа
- үүрэг гүйцэтгэхэд асуудал байхгүй, харин үүргээ гүйцэтгэж дуусаад гэртээ орохдоо халдвар аваачих эрсдэл өндөр байна.
- Цагдааг хүндлэх байдал хангалтгүй
- Шийдвэр ойр ойрхон өөрчлөгддөг
- хэрэгжиж байгаа
- торгууль тавих гэхээр бэлэн мөнгөтэй харьцаж байна, мөн банканд торгуулийн мөнгө тушаахад хүлээгдэх гэх мэт олон бэрхшээл байна, үүнийг хуучин шиг тасалсан хуудсаа мөнгөний хамтаар няравт тушааж баймаар байна
- иргэд гаргасан шийдвэрүүдийг мэдэхгүй байна
- иргэдийн ойлголт тааруу
- хатуу хөл хорионы дэглэм нь хэрэгжихгүй, иргэд алба хаагчдын дунд үл ойлголцол их үүсэж байна
- ажил, ачааллаас болж бэрхшээл гардаг
- иргэд лагерийн байшиндаа очмоор байна гэж шаардлага өөдөөс гаргах юм
- иргэд их бухимдалтай
- миний хувьд гэр бүлийн (нөхөр) хамт цагдаагийн байгууллагад ажилладаг 3-6 насны 2 хүүхэдтэй цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор хоёулаа уртгассан цагаар ажиллахад хүүхэд харах хүнгүй хүндрэлтэй байгааг уламжилж байна.
- учир нь үл ойлгогдох олон шийдвэр гарч байна.
- нийгмийн масстай харилцан уялдахгүй байгаа

- зөвшөөрөл ихээр өгч байгаа болохоор хөдөлгөөний эрчим сулрахгүй байна
- иргэдийн ухамсар муу, шаардлага биелүүлэхгүй байна
- дэглэм сахих ухамсар ихэнх иргэдэд алга байна
- ард иргэдийн эсэргүүцэл их байна
- УОК-ын шийдвэр нь qr кодоор явуулж байгаа ч иргэд нь уг зөвшөөрлийг өөрсдийнхөө бүх нөхцөлд ашиглаж байж болох юм
- тодорхойгүй, нэгдмэл бус байдалтайгаар мэдээлэл өгч байна
- иргэд цагдаа хоёрын хооронд үл ойлголцол гарч байна
- QR код асуудалтай байна.
- Хоорондоо зөрчилдсөн шийдвэрээс алба хаагчид дэмий эргүүл хийж, эрүүл мэндээрээ хохирч байна
- нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна. Дээрээс өгсөн шийдвэр учир дутагдалтай, орон нутагт нийцэхгүй байна, хоорондоо зарим шийдвэр зөрчилдөж байна. Жишээ нь: УБ хотоос гаргачихсан автомашин хүнийг аймгийн төв лүү оруулахгүй байх жишээтэй
- явган хүний хөдөлгөөн их байгаа иргэдийн 100/50% нь шаардлага биелүүлдэг.
- Иргэдийн өдөр тутмын хүнсний асуудал их байна
- Ямар ч ойлгомжгүй гаргасан шийдвэр нь маргааш нь өөрчлөгддөг
- тухай бүрд шийдвэр өөрчлөгдөж байна.
- шинжилгээний хариу гараагүй иргэдийг нэвтрүүлэх эсэхэд
- хөдөө орон нутаг руу явах гээд шинжилгээ өгч байгаа иргэдэд ухуулга яриа хийж, зөвлөгөөг сайн гаргах
- хамгаалалтад ажиллаж буй цагдаагийн алба хаагчдад цалин урамшуулал сайтар олгож, урам зориг өгөх
- ард иргэдийн хуулийн мэдлэг муу байна
- иргэдэд хорио цээрийн үеийн мэдээ мэдээлэл дутмаг байна. Иргэдэд шийдвэр нэг мөр очихгүй байх шиг байна.
- Тийм
- хүний хүчнээс илүү техник технологи ашиглах хэрэгтэй байна. Цагдаа зам дээр зогсож 300 машинд хаашаа явах, хаана ямар автобус байгааг хэлээд зогсож байснаас дуу бичлэг хийгээд чанга яригчаар ярих, зурагт самбар байрлуулмаар байна
- зөвшөөрлийг эзнийг нь олж олгох
- гадуур хөл хөдөлгөөн их байна.
- Ард иргэд хүлээцгүй байдал
- цаг үеийн болон хэрэгжүүлэх ажлын чиглэл хугацаа алдаж ирдэг
- өдөр болгон өөрчлөгдөж иргэд ойлгохгүйгээс маргаан үүсэж байна
- зарим нэг юм ойлгомжгүй байна, нийтийн тээвэр явуулж байж, иргэдийг гэрээс нь гаргахгүй хорих
- иргэд олон нийтэд ойлгомжтой нэг бүрчлэн танилцуулах
- зарим шийдвэрүүд нь нөхцөл байдалд тохирохгүй байна.
- 0 зогсолтын цед зөвшөөрөл олгох тээврийн хэрэгсэлд хязгаарлалтай өгөх багаж техник хэрэгслээр хангах. жич: хаалт, төмөр замын чиглэлийн

- Зарим шийдвэр иргэд, цагдаа хооронд зөрчил үүсгэж байна
- Хамгаалалтын хувцас, маск хангалтай хүртээмжтэй өгөх
- улсын хэмжээнд босоо тэнхлэгийн а0102 замаар хүнсний ачаа тээвэр явахыг зөвшөөрнө гэснээ баахан барилгын материал, гэр ахуйн бараа, уул уурхайн тоног төхөөрөмж зөөдөг
- иргэдийн харилцаа хандлага муу
- УОК, НОК гаргаж байгаа шийдвэр хоорондоо уялдаа холбоогүй мөн төрийн байгууллага хоорондоо уялдаа холбоо муу ажиллаж байна
- иргэд шаардлага биелүүлэхгүй, цээртэй цг хэлэх, өөрсдийнхөөрөө зүтгэх
- ойлгомжтой бэрхшээл байхгүй
- тогтоол шийдвэрээ цэгцтэй шууд ойлгогдохоор гаргадаггүй, бөөрөнхий хоёр талтай байгаа нь албан цүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй
- онцгой комиссийн бичиггүй хэр нь нэвтрэх гэж ирж байна
- зайлшгүй шаардлагатай цед иргэдийг явуулахаас өөр аргагүй байна
- ойлгомжтой байгаа
- замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэдэд мэдээлэл сайн хүргэх талаарх зам хаасан, хөл, хөл хорио тогтоосон, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухай юу ч мэдэхгүй хүмүүс зөндөө байна
- дараагийн шийдвэр нь цаг алдаж ирдэг, ойр ойрхон солигдож байгаа
- иргэд цагдаагийн алба хаагч нар энэ шийдвэрээс болж бэрхшээлтэй байна. хэрэгжүүлэхэд хэцүү байна.
- ажлын цаг, амрах цаг тохиромжгүй байна
- цагийн хязгаарлалттай дэлгүр аж ахуй нэгжүүд ажиллаж байгааг болих уртасгасан цагаар ажиллах
- хувцас, ажлын цүрэг чиглэл бусад байгууллагатай уялдаа холбоотой байх
- хэтэрхий нуруу заавар журам
- иргэд хөл хорио тогтоож байгаа цед гадуур сэлгүцэх асуудал таслан зогсоогдохгүй байна, иргэд худал ярьж эмнэлэг, хүнсний дэлгүрээр үйлчлүлье гэсэн шалтгаанаар хөдөлгөөнд оролцож байна.
- иргэд шаардлага биелүүлэхгүй байх
- хатуу хөл хорио тогтоосон цед иргэдийн хөдөлгөөн мөн нийслэлийн засаг дарга болон УОК-ын тууштай бус шийдвэрүүд.
- ойлгомжгүй зүйл байхгүй
- иргэд эрсдэлийг төдийлөн сайн ойлгохгүй байдаг
- иргэд хэрэгжүүлэхээс зайлсхийдэг
- онцгой комиссоос гаргаж байгаа шийдвэрийг хурдан ойлгомжтой мэдээлэхгүй байна
- иргэдийн зайлшгүй шаардлага, нөхцлийг бодолцож үзээгүй
- иргэдийн харилцааны асуудал их муу байна
- иргэд маш хариуцлагагүй хандаж байна.
- ард иргэдийг аль болох гэртээ байхыг байнга сануулах
- гаргасан шийдвэрүүд уялдаа холбоо муу
- Сэжигтэй тохиолдолтой хүн, надтай постод гарч байна
- тулгарсан асуудал бэрхшээл байхгүй

- оновчгүй шийдвэр зохион байгуулалт байхгүй, уялдаа холбоо байхгүй
- удаан хугацаанд гадаа үүрэг гүйцэтгэж байгаа учир цагийг богиносгох
- хэвийн
- зөв гарц шийдлийг хайх
- зав шийдвэр гаргахгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй
- 24 цагаар үүрэг гүйцэтгэхэд цаг агаарын байдлаас болоод хүйтэн
- өөр хоорондоо уялдаагүй шийдвэрүүд ар араасаа гарч байна
- шийдвэрүүд удаан гардаг, бас тодорхой бус байдаг
- гаргаж байгаа шийдвэр нь хоорондоо зөрцүтэй
- одоогоор ямар нэгэн санал хүсэлтгүй
- гаргасан шийдвэр тогтоомжсоо буцааж байгаад
- бензин тос олгох шаардлагатай байна
- 24 цагаар гарч буй алба хаагчдаа эргүлд татахгүй байх
- онцын шаардлагагүйгээр иргэд маш их сэлгүүцэж байна. Халдвар тархах эрсдэл өндөр байгаа гэж бодож байна.
- гаргаж буй шийдвэрүүд нь дагаж мөрдүүлэхэд зөрцүтэй байна
- Засгийн газрын шийдвэрт тусгагдаагүй асуудлууд байгаа
- иргэд явган болон тээврийн хэрэгслээр зорчиж байгаа шалтгаанаа хурдлаа хэлэх, эмийн сан орно гэх мэт
- зарим иргэд шаардлага биелүүлэхгүй доромжлох тохиолдол гарч байна
- бэрхшээл одоохондоо гараагүй
- нэг мөр биш олон үзүүртэй шийдвэр гаргадаг
- цагдаа, сонсогч олон цаг зам дээр зогсох нь ойлгомжгүй байна
- урьдчилан сэргийлж чадахгүй байгаа маш эрсдэлтэй ажиллаж байгаа
- хамгаалах хэрэгсэл байхгүй маскнаас өөр зүйл байхгүй байна
- хэвлэл мэдээллээр гарч буй шийдвэрүүд албан ёсоор үүрэг чиглэл болж ирэхдээ удаашралтай
- зохион байгуулалт санхүүгийн асуудал муу байна
- иргэд эсэргүүцэж байна
- үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын санхүү болон дархлааг дэмжих
- Аймгийн онцгой комиссын шийдвэр иргэдэд таалагдахгүй байна
- гадаа хүйтэн л байна даа
- ойлгомжтой
- нэгдсэн 1 удирдлагатай байх
- шийдвэр ойлгомжтой, оновчтой байна.
- УОК-ийн шийдвэр нэг талдаа байвал хэрэгжилтийг хангах бидэнд хөнгөн байх юм
- хүйтэн байна
- бэрхшээлтэй асуудал гараагүй
- тусгай хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл шаардлагатай байна
- цагдаа хийх ёстой ажлаа хийж байгаа тийм болохоор тулгарч буй асуудал байхгүй мянган өдөр тэжээж нэг өдөр ашигла
- нэгдсэн нэг шийдвэр гарахгүй байна. Тодорхой биш байна
- зохион байгуулалтгүй байна.
- олон удирдлагатай байна
- иргэд УОК-ын шийдвэрийг дагаж мөрдөхгүй гадуур их явж байна

- авто машины хөдөлгөөн хаах
- бэлэн байдлын цед банк нээж, зарим ойлгомжгүй шийдвэрээс болж хүмүүсийн олноор цуглахаар хүмүүсийн хөдөлгөөнийг нэмэгдүүлсэн
- олон янзаар гарч, өөрчлөгдөж байна шийдвэрүүд
- иргэд захирамж шийдвэрийг дагаж мөрдөхгүй байна
- олон талтай, ойлгомжгүй шийдвэрүүд
- иргэдийн ухамсар муу байна
- иргэд бухимдалтай байна
- иргэдийн ухамсаргүй зарим нэг үйлдэл гэхээс бусдаар гайгүй
- орон нутгийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаа
- урамшуулал олгогдохгүй байгаа
- хангалттай ойлгогдож байна энэ талаар хүн мэдээ мэдээлэлтэй байгаа
- цагдаагийн алба хаагчид эрсдэл ихтэй нөхцөл байдалд цэрэг гүйцэтгэж байна.
- чиг үүргийн давхцал
- тулгарч буй бэрхшээл байхгүй
- хөл хорио хөдөлгөөний хязгаарлалтыг хийх шийдвэрийг баг сум бүрээр нарийвчлан гаргаж газрын зурагт тэмдэглэж алба хаагч нар танилцуулах арга хэмжээ авах.
- гаргасан санал шийдвэр хүмүүцт хүрэхгүй байна, иргэд зарим нэг нь сайн ойлгохгүй байна
- ард иргэд цл тоодог
- иргэдэд чирэгдэл учруулдаг
- шийдвэрүүд удаа дараа өөрчлөгдөж байгаа нь нийцэхгүй байна.
- Тэг зогсолт хийсэн мөртөө маш олон машинд зөвшөөрөл олгодог
- алба хаагчдын аюулгүй байдлыг хангаж өгөх
- ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байна
- шийдвэрүүд харилцан уялдаатай байх
- хөл хориог улам чангатгаж өвчнийг барьж авах
- хатуу хөл хорио тогтоосон гэсэн хэр нь, үйлчилгээ авах ААН нээлттэй байхаар иргэд тэнд үйлчлүүлэх гэж очно. Бид хаашаа явж байгааг лавлахад дэлгүүр орно, ажилдаа явж байна гэх тайлбар хийнэ. Ийм байхад ямар шаардлага тавих вэ. Энэ хүйтэнд үнэхээр 00 зогсолт хийхгүй бол цагдаа гудамжинд даарч зогсох хоорондоо нийцэхгүй байна.
- цагдаагийн байгууллагын алба хаагчдыг арай олон цагаар гудамж талбайд ажиллуулж байна
- яаралтай 0 зогсолт хийх хэрэгтэй.
- шийдвэрээсээ буцаад баймааргүй байна
- хэрэгжүүлэх боломжтой. Байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах мэдээ мэдээллээр хангаж байх
- нэг гаргасан шийдвэрээ байнга өөрчилдөг
- ойлгомжгүй байна шүц дээ
- богино цагаар ажиллах
- иргэдийн хариуцлагагүй байдал

- 14 хоногийн тусгаарлалтад байгаа иргэдийн ар гэрийнхэн нь гадуур явж байгаа нь
- иргэдэд тулгарч буй асуудал дээр тулгуурлаж шийдвэр гаргах
- ойлгомжтой энгийн байдлаар тайлбарласан байх
- УОК-оос иргэдийг хүнс, эмнэлгийн тусламжийг авах тохиолдолд иргэдийг гарч болно, замын цагдаагийн газрын удирдлагаас хөдөлгөөнийг qr зөвшөөрөлтэйг нь ялгаж явуул гэсэн чиглэл өгч байгаа, идэш хоолондоо явах гэж байгаа, хүмүүс цагдаа 2-ын дунд том зөрчил гарч байна. тухайн хүмүүсийг хүнсээ авах гэж байна гэж явуулахаар замын хөдөлгөөн их байна тээврийн хэрэгслүүдийг ялга салга гэдэг.
- гэрийн тусгаарлалтад байгаа иргэд амны хаалтыг тогтмол зүцхгүй байна. хамт амьдарч байгаа иргэд гэрээс гарах эрх нь бүрэн нээлттэй байгаа тул хэрэв халдвар авсан иргэн гэрийн тусгаарлалтад байгаа бол гэр бүлийн гишүүдээр дамжин халдварлах эрсдэлтэй байна.
- улсын онцгой комисс, засгийн газар нэг шийдвэртэй баймаар байна түүнийг нь хүчний байгууллага хэрэгжүүлж иргэд ёсчлон биелүүлж нэг шийдвэрээ дагах
- иргэдэд мэдээллийг маш ойлгомжтойгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр танилцуулж мэдээллээр хангах
- шийдвэрүүд зөрцүтэй байна, нэгдсэн нэг удирдлага шийдэлд хүрч ажиллах
- зарим шийдвэр нь хоорондоо уялдахгүй байдаг
- гаргасан шийдвэрүүд нь хөрсөн дээр буудаггүй ард иргэдийг их төөрөгдөлд оруулж зохион байгуулалт муу байгаа учраас иргэдийг их бухимдуулж байна. Мөн бэлэн байдлын цед ажиллаж байгаа алба хаагчдын хангамж муу байгаагаас халдварт өртөх эрсдэл өндөр байна, маск бээлийнээс авхуулаад хангалт муу байна, хангалт өгөөч гэхээр та нар тангараг өргөсөн өөрсдөөсөө гарга гэх мэт утгатай хариулт өгдөг, хаа хаанаа энэ тал дээр анхаарах хэрэгтэй. Мөн алба хаагчид байнгын элжинд өдөр шөнөгүй хоног өдрөөр ажиллаж байгаа хоолны мөнгийг тогтмол цалин дээр нь олгож байх шаардлагатай байна. Энэ нь зөвхөн коронагийн цед биш, бусад цед ч бас хоолны мөнгө тогтмол олгож баймаар байна.
- олон чиглэлтэй
- шаардлага эсэргүүцэх
- алба хаагчдын хангалт дутмаг
- тодорхой, тогтвортой, хүчтэй шийдвэр байхгүй
- аль ч шийдвэр нь иргэдээс түлхүүц ирж байгаа хүндрэл бэрхшээлд хариулт болж чаддаггүй
- шийдвэр
- хөл хорио илүү чанга баймаар байна
- гаргах гэж байгаа шийдвэрээ яг баттай хэрэгжих цаг хугацаа, үр дүнгийн талаар мэдээлэл хийж баймаар байна. Засгийн газар, УОК-оос гарсан шийдвэрийг хүн болгон өөр өөрийнхөөрөө ойлгож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

- согтууруулах ундааг худалдан борлуулахыг удаан хугацаагаар хоригломоор байна. Ачаалал нэмж байна.
- УОК ЗГ-аас гаргаж буй шийдвэр ард иргэдэд бүрэн хүрэхгүйгээс болж төрийн алба хаагчтай үл ойлголцолд хүрдэг
- ахуйн үйлчилгээний газрууд хаалттай байгаад иргэд их бухимдалтай байна, жишээ нь дугуй засвар, машин засвар, барааны дэлгэцэр гэх мэт
- ойлгомжтой гэхдээ хэрэгжүүлэх явцад гаргасан шийдвэр нь ард иргэдэд таалагдахгүй байгаа учраас маргалдах явдал гардаг
- гаргасан зарим шийдвэр нь хурдан өөрчлөгдөөд байгаа нь
- УОК шийдвэр иргэдтэй хэрэлдүүлж, цагдааг буруутгуулж байна.
- нэгдсэн нэг ойлголт байхгүй байна
- олон удаа шийдвэр солигддог
- мэдээлэл нь иргэдээс хоцорч алба хаагчид дээр ирдэг зарим иргэдийн асуусан зүйлсийг мэдэхгүй байх жишээний
- гаргасан шийдвэрээ өдөр болгон өөрчилдөг. Дагаж мөрдөхөд хүндрэлтэй
- иргэдэд хатуу шаардлага таарвал эсэргүүцэл үзүүлнэ, эргээд алба хаагч буруудах эрсдэлтэй байдаг
- ажиллахад дархлаа дэмжих бэлдмэл, эм тариа зэргийг алба хаагч нартаа хангалттай тарааж өгөх
- иргэд зарим газрын дэглэм сулруулснаас тэр явж байхад би яагаад болохгүй гэж тайлбар тавьдаг.
- Эргүүлийн цаг хэт урт байна. Даарч дархлаа унаж байна. Ээлжийн хугацааг богиносгох
- Ажилдаа явж байна гэж тайлбар хийдэг
- маш их цаас ирж байна
- байгууллагууд үялдаа холбоо байхгүй, ЗГ холбогдох газраас гаргаж байгаа тогтоол шийдвэр тодорхойгүй, бөөрөнхий хэрэгжилт маш муу
- иргэд коронавирусийн талаар мэдээлэл муу байна, шаардлага хүлээж авахгүй, хүндрэлтэй байгаа зарим шийдвэр нь тодорхой биш
- эрүүл мэндийн байгууллага, хөдөө явах автобусны хуваарийн талаарх мэдээлэл маш муу байгаад иргэд их бухимдаж байна. Хаана шинжилгээгээ өгч, хэзээ автобус захиалгад орохоо мэдэхгүйгээс болж байна.
- Хэвийн
- хөл хорио гэх нэртэй л болохоос биш хөдөлгөөн их байгаа ийм цед цагдаа нарын аюулгүй байдлыг хангах
- цаг тухайд нь танилцуулдаггүй
- хүмүүс дэглэм сахихгүй бөөгнөрөл үүсгээд, шаардлага тавихаар биелүүлэхгүй байна.
- зарим нэг иргэд шаардлага биелүүлэхгүй байна
- хүмүүс цагдаагийн албан хаагчийн шаардлагыг биелүүлэхгүй байна
- бид иргэдийг хамгаалж ажиллаж байгаа боловч өөрсдөө эрсдэлтэй бүлгийн хүмүүс болж байна
- иргэд иргэний үүрэг, хорио цээрийн дэглэмээ сахих нь өөрийн болон бусдыг эрсдэлээс хамгаалж байгаа гэдгээ ойлгохгүй байна

- иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч байна
- сайн мэдэхгүй байна
- одоо ер нь гарах шаардлага байгаа юм уу, бүгд ухамсарласан, зүгээр бэлгэдлийн зориулалттай зогсож байна.
- гаргаж байгаа шийдвэр нь тодорхой бус аль байгууллага хэрхэн ажиллах нь тодорхой бус, бүхнийг цагдаагаар хийлгэж байна
- хүйтэнд бага цагаар зогсоомоор байна
- зарим нэг шаардлагагүй постыг буулгах хэрэгтэй
- гаргасан шийдвэрүүд нь хоорондоо зөрдөг, үүнээс үүдэн иргэдэд шаардлага тавихад хүндрэл учирдаг.
- Автобус удаан хүлээж даарсан иргэд автобусанд орж чихэлдээд ямар ч хорио үзэрийн дэглэм гэж хэлээд ч нэмэргүй байна. Чиглэлд явах автобусныхаа тоог нэмэх хэрэгтэй
- авто эргүүллийн лада машины бензин шөнөдөө хүрэхгүй хүндрэлтэй хувиасаа мөнгө гаргаж байна
- тусгаарлалтад байгаа иргэдийн ар гэр гадуур ажлаа хийгээд явж байгаа ийм үед 1 өрөө байранд хамт байгаа хүнийг тусгаарлах хэрэг байна уу гэсэн асуулт ирсэн
- хүмүүс нөхцөл байдлыг бүрэн дүрэн ойлгохгүй байна
- хэвийн
- иргэдийн ухамсар муу байна
- хатуу хорио дэглэмийг алба хаагчид дүцрэгүүд жигд тавихгүйгээс иргэд танай тэнд ингэж байхад чи ойлгосонгүй, тэр дүцрэг тэнд зүгээр байхад гэх мэтээр шаардлага тавьж ажиллахад хүндрэлтэй байна
- амралтын өдөр байхгүй хагас бүтэн сайнгүй ажиллаж байна, ажлын ачааллаас болж ар гэрт үл ойлголцол их байна даа
- иргэдийн эрх ашиг болон алба хаагчийн тавьж байгаа дүрэм журам их зөрчигддөг
- улсын онцгой комиссын гаргасан шийдвэр бодит байдал дээр зөрж хэрэгждэг
- байгууллага хооронд ямар ч уялдаа холбоо байхгүй
- тулгамдаж байгаа асуудал байхгүй
- цагдаа ажилла гээд хөл хорио ямар ч хэрэг алга
- хүмүүс тал нь явж болоод байхад барьцаж байна, адилхан дамжина биз дээ гэж байна
- автобусны буудал дээр цагдаа хэчнээн шаардлага тавьж зай хоорондыг сахиулж байгаа хэдий ч автобусанд ороод дэглэм алдагдаж байна.
- нэг ойлголтод хүрээгүй, улсын хэмжээнд нэгдсэн маягт байхгүй төрийн алба нь уялдаа холбоогүй байна.
- хэвийн
- тусгаарлалтад байгаа хүнтэй хамт амьдрах ажилдаа явах асуудал ойлгомжгүй байна
- хориог нээх
- дээрээс өгсөн шийдвэрийн дараагийн шатны дарга нар буруу тайлбарлаж байна.

- улсын онцгой комиссын шийдвэр судалгаагүй, тодорхой нэг зүйл рүү шууд чиглэгдээгүй, бөөрөнхийлсэн, цүнийг нь алба хаагч нар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй
- нэг гаргасан шийдвэрээ бүрэн хэрэгжүүлэх, нэг захирамжаа гаргачаад дахин өөрчлөөд иргэн цагдаагийн алба хаагч нарын дунд үл ойлголцол үүсэж байна.
- автобусны буудлаар маш олон цагаар зогсох нь ямар ч үр дүнгүй асуудал болж байна
- халдвар авах өндөр эрсдэлтэй
- хатуу чанга байх шийдвэр гаргах хүсэлт тавих нь сул үр дүнтэй
- улсын онцгой комиссоос гаргаж буй шийдвэр нь эргэж буцсан иргэд цагдаа хоёрын хооронд ойлгомжгүй, зөрчил үүсдэг
- тусгай алба, эмнэлгийн хүн хүчээ зөв тооцоолж зохион байгуулалтад оруулах, хязгаарлалт, хориглолт гэж захирамж гарж байгаа ч гэсэн сүүлийн үед иргэд чөлөөтэй зорчиж байна
- зүгээр
- иргэдтэй зөв боловсон харьцаж иргэд шаардлага биелүүлдэг.
- цагдаагийн орон тоо муу байна
- орой цугламааргүй байна
- ойлгомжгүй, гаргасан шийдвэрээ олон дахин өөрчилдөг
- алба хаагчаас тавьсан шаардлагыг иргэд биелүүлэхгүй эсэргүүцэж, онцын шаардлагагүй хэр нь гадуур сэлгүүцэх байдалтай байна.
- тусгаарлалт
- иргэдэд хоорондын зай барих талаар ухуулга сурталчилгаа бага явагдаж байна
- шийдвэрүүд нь эргэж буцсан байдалтай байна
- монголын хууль 3 хоног гэдэг шиг эргэж буцсан шийдвэрээс ард иргэдэд шаардлага тавихад түвэг учруулж байна.
- иргэдийн ухамсар дорой байна
- дуудлага өгсөн иргэд гэртээ оруулахгүй байна
- дэглэмээ бууруулах
- одоогоор ямар нэгэн санал хүсэлт алга байна аа
- 1 өдрийн хууль
- иргэдийн ухамсар муугийнх байх
- аймаг орон нутаг болгоны онцгой комисс нь өөр өөр шийдвэр гаргаж, өөр өөрсдийнхөөрөө хорио үзэр тогтоож байгаа нь постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид муудалцаж маргалдахад хүрч байна.
- шийдвэр нь оновчтой бус байдаг
- алба хаагчдын аюулгүй байдалдаа анхаарахыг хүссэн ч өнөөгийн нөхцөл байдал нь боломжгүй байна
- иргэд шаардлага биелүүлбэл асуудал үгүй
- иргэд муу ухамсарлаж зөвхөн амин хувца бодож байна
- ард иргэд их бухимдалтай янз бүрийн шалтгаан хэлж нэвтрэх гэж байна, нэвтэрсэн нутгийн иргэдийг шинжилгээ өгч ир гэдгийг шаардаж байгаа, хүмүүс нүүрс, хивэг, тэжээл зөөсөн хүмүүс ирж байна, бас дээр нь өвлийн мах, тэжээл авах гэсэн хүмүүс бас ирж байна

- иргэд их бухимдалтай байна, шаардлага биелүүлэхгүй байна, 24 цагаар ажиллаад амрах хугацаандаа явган эргүүлд явж байна, дархлаа унаж байна, ингэснээр вирус тусах магадлал өндөр байна.
- ээлжилж ажиллаж, нэгнийгээ амраадаг байх
- хорио цээр сунгаад л байдаг хэр нь үр дүнд хүрэхгүй, хэн нь юу хийхээ мэдэхгүй байна
- иргэдийн ухамсар дорой ойлголт байдаггүй
- орон нутагт цүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нар ачаалал маш их байна.
- нарийн судалгаан дээр үндэслэж, бодитой шийдвэр гаргаж баймаар байна.
- гаргасан шийдвэрээ буцаадаг буруу
- цагдаагийн алба хаагч энэ хорио цээрийн цед эргүүлд гарч байгаа нь одоогийн байдлаар яг юуг юу хийгээд, хориод, эргүүлд гараад байгаа нь ойлгомжгүй байна.
- маск, нэг удаагийн бээлий өгмөөр байна
- цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцэж байна
- хүйтэнд удаан зогсож чадахгүй байна. Дулаацах гээд хэсэг зуур нэг газарт орсон хойгуур шалгалт ирж таарвал загнуулдаг.
- УОК шийдвэрээ иргэдэд мэдээллийн хэрэгслээр хангалттай хэмжээнд танилцуулж байх шаардлагатай байна.
- иргэд хорио цээр гэдгийг ухамсарлахгүй, өөрийнхөөрөө зүтгэх
- иргэдийн хөдөлгөөний урсгал өмнөх шигээ байна, цагдаа гадаа эргүүлд ажиллах шаардлагагүй юм шиг санагдаж байна
- хорио цээрийн дэглэмийг мөрдөхгүй байна
- гарсан шийдвэр нь хуулийн байгууллагын үйл ажиллагаанд нийцэх зүйл ховор, гаргасан шийдвэрийн тайлбар бага учир иргэд ойлгодоггүй
- яг хатуу чанга хөл хорио юу, эсвэл нийтийн тээврээр болон явганаар иргэд хаашаа ч хамаагүй зорчиж болох уу.
- хөл хориог илүү чангатгах хэрэгтэй
- цүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байна
- шаардлагагүй цед гадуур зорчиж байгаа иргэд тааралдахад хүлээлцэх хариуцлагын механизм байхгүй, иргэд гадуур зорчих хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаагүй нийтийн тээвэр зэргээр зорчиж байхад гудамжинд хүйтэнд зогсож олон цагаар цүрэг гүйцэтгэх нь өвчлөл үүсгэх эрсдэлтэй байна.
- бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан алба хаагч нар жигд шаардлага тавимаар байна, жигд шаардлага тавихгүй байгаагаас иргэд, алба хаагчдад ажиллахад хүндрэлтэй байна.
- хөл хорио
- өдрийн хоолны чанар, халуунаар өгөх зэрэгт анхаарах
- гэр бүлдээ зарцуулах цаг зав байхгүй байна
- иргэд шаардлага биелүүлэхгүй байна
- голомтын бүсээс хүмүүсийг гаргаж байгаа нь энэхүү өвчний цар тахлыг нэмэгдүүлнэ, голомтын бүсийг чангатгаж эрүүл бүсүүдийг урьдчилан сэргийлж ажиллах шаардлагатай байна.
- тээврийн хэрэгслийн зөвшөөрлөө багасгах хэрэгтэй

- дээд удирдлагын шийдвэр
- ямар цаг хугацаанд ямар шийдвэрээр ажиллах нь ойлгомжгүй байдаг. УОК, НОК, дүцргийн ОК зэргийн шийдвэр харилцан адилгүй, нэг цаг хугацаанд гардаггүй.
- зарим үйл ажиллагаа нь хэлбэр төдий байна гэх мэтээр санал сэтгэгдлээ нээлтэйгээр илэрхийлсэн байна.

Асуулт 8. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, өгч буй үүрэг, ажлын чиглэлтэй хэрхэн танилцаж байгаа вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнээс 52,9 хувь нь Цахим хуудсаар буюу өөрсдийн дотоодын фэйсбүүк группээс танилцаж байгааг илэрхийлжээ.

Хүснэгт №4. Удирдлагын шийдвэр, үүрэг, ажлын чиглэлтэй танилцаж буй байдал

	Frequency	Percent
Амаар	52	4,9
Бичгээр	187	17,6
Valid Шууд удирдах даргаас	242	22,7
Хамт ажиллаж байгаа алба хаагчаас	21	2,0
Цахим хуудсаар /хэлтсийн фэйсбүүк груп/	563	52,9
Total	1065	100,0

Диаграм №11. Удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэлтэй танилцаж буй байдал



Асуулт 9. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, өгч буй үүрэг, ажлын чиглэл нь ойлгомжтой байна уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 99,1 хувь нь буюу 1055 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Тийм гэж 1007 алба хаагч буюу 95,5 хувь нь, Үгүй гэж 48 алба хаагч буюу 4,5 хувь нь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 95,5 хувь нь нь удирдлагын шийдвэр, өгсөн үүрэг, ажлын чиглэлийг ойлгомжтой гэж үзсэн байна.

Диаграм №12. Удирдлагын шийдвэр, өгсөн үүрэг, ажлын чиглэлийн ойлгомжтой эсэх



Асуулт 10. Хэрэв ойлгомжгүй болон хэрэгжүүлэн ажиллахад тулгарч буй бэрхшээл байгаа бол та саналаа нээлттэйгээр илэрхийлнэ үү? гэсэн нээлтэй асуултад 853 алба хаагч ямар нэгэн бэрхшээл байхгүй болохыг илэрхийлсэн бол 20,4 хувь нь дараах байдлаар тулгарч буй бэрхшээл хүндрэлийг нэрлэсэн байна. Үүнд:

- Үүрэг даалгавар хөрсөн дээр бүрэн буухгүй, хэрэгжихгүй байна.
- Орон нутагт ирж байгаа хүмүүсийг гэрт нь биш өөр газар тусгаарлах
- ямар нэгэн тулгарч байгаа асуудал байхгүй
- Салаа утгатай
- Хүн хүч дутмаг, техник хэрэгслийн хүрэлцээ муу байна
- Зөвшөөрөл олгож байгааг багасгах
- Нэг мөр хэрэгжүүлэн ажиллахад хүндрэлтэй
- Удирдах даргаас өгч байгаа зарим үүрэг чиглэл оновчгүй байна, нутаг орны онцлог олон нийтийн сэтгэл зүйг ойлгохгүй тал байна

- Уялдаа холбоо
- Удирдлагаас өгч байгаа шийдвэр алба хаагчид руу чиглэсэн баймаар байна
- Аюулгүй байдал тусгай хувцас хэрэгсэл
- Одоогоор хүндрэл гараагүй
- Хол хориогоо чангатгаж зорьчих зөвшөөрлийн тоогоо хязгаарлаж, шалтгаан нөхцөлийг сайн тодруулж байж бичиг хиймээр байна, ямар ч зорилго байхгүй дэмий сэлгүүцэж эрсдэл дагуулж байгаа иргэд олон байна
- Хамгаалалтын хувцас, бээлий, бусад зүйл
- ойлгомжгүй байна
- Ард иргэдэд маш сайн сонорт нь хүргэх
- иргэдэд мэдээллийг сайн хүргэх
- Олон дарга нарын тоог бууруулж, гудамжинд ажиллах алба хаагчдыг нэмэх
- Иргэд өөрсдөө хайхрахгүй байгаа нь
- Зурагт радиогоор их сэрэмжлүүлэг явуулах
- Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх
- Хол хорины цед томоохон хэмжээний хүнсний зах, супер маркет зэргийг хааж байх хэрэгтэй байна.
- туйлширдаг
- Хүйтэнд удаан хугацаагаар эргүүл хамгаалалтад, жижигч харуулууд байнгын тулаа хийж байна
- Нэг шийдвэрээр ажиллах шаардлагатай байна
- Хэт олон цагаар цүрэг гүйцэтгэж байна
- Хоол ундны чанар тааруухан байна
- онцгой комиссын шийдвэр цагдаагийн байгууллагын зарим асуудалтай нийцэхгүй байна
- УОК, НОК-оос гаргаж байгаа шийдвэр оновчгүй байгаагаас иргэд алба хаагчдыг дэмий ядрааж байна
- Эргүүлийн цагийг богиносгох
- Бүгд биш боловч харилцан 1 ойлголттой болоогүй.
- Хангалт сайн тавих
- Зарим ААН нээгдсэнтэй холбоотой иргэдийн хөл хөдөлгөөн их байна гэж -42 иргэн
- Зарим цед мэдээлэл бага байна
- Автобусны хөдөлгөөн хориглох
- Жишээ нь: Банк дээр цагдаагийн алба хаагч бүтэн өдөр хамгаалагч харуулын ажил хийх шаардлага байна уу. Банкаар хүмүүс бага үйлчлүүлж ямар нэгэн бүлэг бөөгнөрөл үүсгэсэн, бөөгнөрч оочирлосон асуудал огт гараагүй байхад цагдаагийн алба хаагчийг татаж өөр хэрэгтэй газар тавьж болохгүй юм уу.
- Хэт их тушаал шийдвэр алба албанаас ирж байгааг нэг цонхоор гаргах
- Иргэдэд ойлголтыг сайн хүргэх
- Мэдээлэл их байгаа
- Хөдөө орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдыг үл тоодог.

- Ажиллаж амьдрах нөхцөлөөр хангах явдал маш муу байгаа*
- *шууд удирдах албан тушаалтнаас цэрэг чиглэл авч ажиллаж байна*
 - *Албанд авто машин*
 - *Нэгдсэн 1 мэдээллээр хангах*
 - *Зарим алба хаагчид илүү цагаар ажиллаж байгаа*
 - *Явган эргүүл одоо юу хийхээ сайн мэдэхээ байсан байна. Иргэдийг гаргах үггүйгээ*
 - *Алба хаагчид амралтгүй ажиллаж дархлаа сулрах гэр бүлд таагүй уур амьсгал үүсэж байна*
 - *Давхардал ихтэй дээд газраас ирж байгаа шийдвэр доод шатанд хэрэгжихэд хүндрэлтэй.*
 - *Алба хаагчдад урамшууллыг нь ялгаваргүй олгуулах*
 - *Цахим болон бичгээр ойлгомжтой танилцуулагдаж байгаа*
 - *Эргэж буцаж байна*
 - *Гадаа хүйтэн байна*
 - *Ард иргэд тависан шаардлага биелүүлэх*
 - *Иргэд гаргасан шийдвэрүүдийг мэдэхгүй байна*
 - *Дарга нар хувь хүний зүгээс тохиромжгүй үүрэг даалгавар өгч байна, бас хоол цай авч ирээд зүгээр очихгүй зураг дарж өөрийн цахим хаягтаа оруулж байгаа нь таалагдахгүй байна*
 - *Иргэдийн харилцаа хандлага ухамсартай холбоотой асуудал л их байна даа*
 - *Нийтийн тээвэр болон зарим ААНБ-ын үйл ажиллагааг ажиллуулснаар хөл хорио тогтоож чадахгүй байна, цагдаагийн байгууллага ямар ч үр дүнгүй ажиллаж байна*
 - *Дэглэм сайн сахих*
 - *Ард иргэдийн эсэргүүцэл их байна*
 - *Тусгай хувцас хэрэгслээр хангах*
 - *Онцын шаардлагагүй тохиолдолд алба хаагч нараа амрааж байх хэрэгтэй байна.*
 - *Нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна гаргасан шийдвэрүүд хоорондоо зөрчилдөж байна. Жишээ нь: УБ хотоос шинжилгээ өгөөд код авсан иргэд аймаг руу орж чадахгүй саатуулагдаж байна*
 - *Иргэдийн ухамсар муу байна.*
 - *Хүн хүчний хуваарилалт тааруу байна*
 - *Хамгаалалтад ажиллаж буй цагдаагийн алба хаагчдад цалин урамшууллыг нэмэх*
 - *ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хэрэгтэй байна*
 - *Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах торгуулийн төхөөрөмж*
 - *иргэдийн хөл хөдөлгөөнийг хоригж, хорио цээрийн дэглэмийг сахиулж гадуур гаргахгүй байх*
 - *Ачааллыг тэнцвэржүүлэхгүй олон цагаар ажиллаж байна*
 - *Иргэд олон нийттэй нэн түрцүнд ажилладаг цагдаагийн алба хаагчдад нэг чиглэл удирдлагаар хангаж гарсан мэдээ мэдээллийг эхний ээлжид мэдэж баттай мэдээллийг олон нийтэд хүргэх*
 - *Ард иргэд цагдаа хооронд үл ойлголцолд хүргэж байгаа зүйл бол авто машинтай зорчуулах. Үүнийг нь шийдээд өгчихмөөр байна.*

- Ажлын цагийн багасгах
- Иргэдийн ойлголт муухай
- УОК болон НОК-ын гаргаж байгаа шийдвэр хоорондоо уялдаа холбоо муу байгаа мөн төрийн байгууллага хоорондоо уялдаа холбоо муу байгаа
- иргэд шаардлага биелүүлэхгүй цээртэй цг хэлэх, өөрсдийнхөөрөө зүтгэх
- онцгой комиссын бичиггүй иргэд ирж байна
- ойлгомжтой, мөн хувцасны хангалт байхгүй
- Хөдөлгөөн хязгаарласнаа ойлгомжтой болгож, хэвлэл мэдээллээр цацаач ээ. Иргэд ямар ч мэдээлэлгүй байна.
- Ойлгомжгүй зүйл байхгүй
- Алба хаагчийн цагийн зөв хуваарилалт
- Бага дунд шатны албан тушаалтан цүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийг махалж байна үнэндээ.
- Цалингийн нэмэгдэл байгаа үгүйг мэдэхгүй байна, илүү цагаар байнга ажиллаж байна
- Дэлгүүрийг хэвийн ажиллуулах
- Ажлын цагийг багасгах, аюулгүй байдлыг байнга анхаарах
- Үнэндээ энэ ажилд маш олон дарга, олон талаас цүрэг өгч, ойлгомжгүй болгож байна.
- Ойлгомжгүй зүйл байхгүй.
- Иргэд шаардлага биелүүлэхгүй байх
- Зарим тохиолдолд одоогийн байдлаар замын хажууд ямар ч хэрэггүй цагдаа, сонсогч нарыг зогсоож байна, үр дүнгүй
- Иргэдийн ухамсар муу
- Иргэдийн зайлиггүй нөхцөл шаардлагыг бодолцож үзээгүй
- Халдвар хамгааллын хэрэгсэл дутмаг байна.
- Хувийн машинтай алба хаагчид дулаацах ч машингүй эргүлд гарч байгаа нь эрсдэл өндөр байна. Гудамжинд өдрийн хоолоо идэх тохиолдол ч байна.
- Аймаг дээр тусгаарлалтад байсан хүүхдүүд, сум дээр ирээд 14 хоног тусгаарлалтад байх хугацаанд эцэг эх, ар гэрийнхэн постод хамт гараад байж байна. Энэ зөв үү. Хавьтагч болчихоогүй биз дээ.
- шийдвэр нэг мөр биш байна
- 24/24 цагаар ажиллуулмааргүй байна. Ядахдаа 3 ээлж болгож өгөөч
- Аливаа ямар ч ажлыг хүний хүчээр шийдэх хандлагатай болчихсон байна
- Алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах хэрэгтэй байна
- Гаргаж буй шийдвэрүүд нь нэг мөр ойлгомжтой байх хэрэгтэй байна
- Гадаа хүйтэн учраас бензин тос олгох шаардлагатай байна
- Зам хааж байгааг ойлгохгүй байна
- Дээр дурдсантай ижил бодолтой байна
- Амрах нөхцөл бага эрүүл мэнд муудах илрэл үүсэж болзошгүй
- ЗГ-ын шийдвэрт тусгагдаагүй байдал их байна
- Иргэд зорчиж байгаа шалтгаанаа худал хэлэх эмийн сан орно гэх мэт

- Зарим иргэд шаардлага биелүүлэхгүй хэл амар доромжлох тохиолдол гарч байна
- ЦАХ, Дотоод хэргийн их сургуулийн сонсогч нар олон цагаар зогсох нь ойлгомжгүй
- хууль эрх зүйн зохицуулалт хэрэгжилт сул
- Бүх алба хаагч нар хичээн ажиллаж байна
- Нэгдсэн 1 удирдлагатай байх
- Тусгаарлах байранд байрлаж буй иргэдийг зөрчил гаргуулахгүй тал дээр ажил арга хэмжээ зохион байгуулах
- Бэрхшээлтэй асуудал шийдвэр л байна. Бусдаар цүрэг гүйцэтгэх хэвийн
- Багахан хугацаанд дулаацаж байхад хэрхэн яаж ажиллаж байна гэдгийг бүрэн мэдээгүй байж ирчхээд загнадаг.
- Авто машины хөдөлгөөнийг бүрэн хаах
- Нэг шийдвэртэй байх
- Архи согтууруулах ундаа ихээр хэрэглэж байна
- Хоорондын уялдаа холбоо муу учир хэрэгжүүлэхэд хүндрэлтэй
- Иргэдийн бүхилдал
- Орон нутгийн удирдлагаас өгч байгаа шийдвэр
- 1,5-2 метрийн зайнаас харьц гэж анхааруулж байгаа хэдий ч цагдаагийн алба хаагчид тухайн жолооч иргэний бичиг баримт болон зөвшөөрлийг тулган шалгахад гарт барьж ойроос нүдээр харьж шалгахад өөр аргагүй байдаг
- Томилгоотой цед орхигддог тул таниулах боломжоор хангах
- Тулгарч буй бэрхшээл байхгүй
- Хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалтыг хэрэгжүүлэх эрх зүйн актад бүслэлийг тодорхой тусгаж нарийвчлан гаргах.
- хэт их цүрэг чиглэл өгч байна, санал асуулга авч байна, тэр санал болгоны харууг хэрэгжүүлж байгаа зүйл байхгүй байна
- Бэрхшээлтэй гэх зүйл одоогоор байхгүй байна
- Алба хаагчдад урамшуулал олгох
- Хатуу хөл хорио тогтоосон байтал зарим ААН ажиллуулж байгаа нь бүх нийтийн бэлэн байдал, хатуу хөл хорионд нийцэхгүй байна. Ийм байж алба хаагчдаа хүйтэнд дааруулж гадаа зогсоож байх ямар хэрэг байна.
- Мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулж байна
- Иргэд зөрчилдсөн шийдвэрчүүдээс болж алба хаагчдаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байна
- Хүнсний хангамжийн жолооч нар халдвар хамгаалал муу байна.
- Гадаа хүйтэнд алба хаагчдыг 30-1 цаг хүртэлх хугацаагаар зогсоож рапорт танилцуулж алба хаагчдын биеийн эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй хүйтний эрч чангарч байгаа энэ цед дотор өглөөний яриаг хийж баймаар байна.
- хэрэгжүүлж ажиллахад ойлгомжгүй бэрхшээлтэй зүйл байхгүй.
- Үл тоох шинжтэй
- Богино цагаар ажиллах
- Урамшуулал олгох

- Ойлгомжтой байна
- Автомашины шатахуун хүрэхгүй байна
- бэрхшээл хүндрэл байхгүй
- Иргэдийн түлгарч буй бэрхшээлийг харгалзан үзэх
- Түлгарч байгаа бэрхшээл байхгүй
- Өдөрт хэдэн зуун тээврийн хэрэгслийг шалгахад
- Улсын онцгой комисс Засгийн газар нэг шийдвэртэй байя
- Эргүүл жижигчир авто эргүүл дээр ээлжид гарч байгаа хүмүүсээр материал шалгуулах, ээлжээс буусан цед хурал цуглаан илүү дутуу юманд дууддагийг нь ойлгодоггүй, хэлэхээр тангараг өргөсөн бол ир чадахгүй бол дараагийн ажиллах хүч нь байгаа шүү бараг зайлаарай, арга хэмжээ тооцно гэдэг. Мөн ажиллах нөхцөлөөр хангаагүй байж шаардлага их тавьдаг материал шалга гэнэ материал шалгахад тусгайлсан хүн асуух өрөө 1-10 байх компьютер комоороо, принтер, принтерийн хор, канон, ширээ, сандал, бичгийн цаас, утасны нэгж гэх мэт зүйлс шаардлагатай болдог энэ бүгдийг өөрсдөөсөө гаргахад хүндрэлтэй байдаг.
- Алба хаагчдын ар гэрт анхаарал хандуулах
- Аливаа үүрэг даалгавар тушаал хэт тоймтой цөөн үгээр эргэлзээтэй бичигдэж ирээд алба хаагчид олон талаас харж ойлгоод хэрэгжилт нь нэгэн жигд биш байна
- Ажлыг зөв зохион байгуулах. Дарга өглөө, оройдоо мэдээ өгдөг учраас хэлтэс дээр хагас бүтэн сайнгүй байдаг. Доод талын алба хаагчдаа мөн дэмий ажил дээр байлгаж ядраагаад байна. 11 дүгээр сарын 11 нд түргэн цугларч ирснээс хойш өглөө 7-оос орой 00 цаг. Сүүлийн хэд хоног өглөө 8-аас орой 22 цаг хүртэл ажил дээр байна. 21 цагт явчихвал бөөн юм болно. Энэ нь хагас бүтэн сайн харгалзахгүй
- Шийдвэр
- Ард иргэдэд хүргэх зөвлөмж зөвлөгөө нь зөрөлдөх асуудал бага сага байх шиг санагдсан
- шийдвэр чиглэлүүд нь ойлгомжтой, гэхдээ иргэдэд таалагддаггүй учир хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг
- Улсын онцгой комиссоос гарч байгаа шийдвэрүүд байнга солигдож байна
- Удаж ирдэг, мэдээлэл хурдтай биш
- УОК-ын шийдвэр өөрчлөгдөхгүй, тогтвортой байх хэрэгтэй байна.
- Хүн бүр хичээх хэрэгтэй. Заавал цагдаа хорьж байх албагүй
- Иргэдэд хатуу шаардлага таарвал эсэргүүцэл үзүүлнэ, эргээд алба хаагч буруудах эрсдэлтэй байдаг,
- Эргүүцлийн цаг хэт урт, хоолны чанар муу, хүйтэн байна.
- Халдаргүйжүүлэлтийн хувцасны хангалт муу шатах тослох материал хүрэлцэхгүй, оновчтой тушаал шийдвэр гарахгүй, хүн хүчээ зөв оновчтой зохион байгуулахгүй байна.
- Ойлгомжтой байгаа
- Эмнэлэг, НОК-ын уялдаа, хамтын ажиллагаа байхгүй, ажлын зохицуулалт байхгүй, байсан ч тэрийгээ мэдэж байгаа хүн байхгүйгээс ард иргэдэд чирэгдэл учруулж үүнээс болж цагдаагийн

- хооронд үл ойлголцол үүсэж бухимдах иргэд их байна.
- Хэвийн
 - Олон дарга нар өөр, өөр үүрэг тавьж дунд нь загнуулдаг.
 - Үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаа машинтай машингүй байдлыг харгалзан хуваарь гаргах хэрэгтэй
 - Хувьдаа машингүй алба хаагч эргүүлд ирэх очих хүндрэлтэй байна.
 - иргэд шаардлага биелүүлэхгүй байна
 - Ойлгомжтой байгаа
 - цагдаагийн хүн хүч хүрэхгүй байхад олон төрлийн үүрэг өгч байна, бас прокурорын байгууллага мөрдөгч нарт энгийн үед тавьдаг шаардлага тавьж дарамт үзүүлж байна, цагдаагийн ар гэр хаягдаж байна, дарга, ахлахуудад ямар ч амрах цаг зав байхгүй өдөр болгон 14–19 цаг ажиллаж байна нэгж дээр
 - Нэг өгсөн үүргээ олон дахин өгдөг
 - Буудал дээр зогсоод ямар ч үр дүн алга
 - Хэт хүйтэнд ажиллаж байна.
 - Иргэд муу мэдээлэлтэй байдлаас болж ажилд их хүндрэл учруулж байна, мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах чиглэлээр ажиллах шаардлагатай байна
 - Бүх үйлчилгээ, зарим замаа нээж хүний хөл хөдөлгөөнийг тавьчхаад эргээд цагдаагийн алба хаагчдаар хүний хөл хөдөлгөөнийг хязгаарла гэсэн үүрэг өгч байна. Мөн орон нутаг хоорондын тээвэрт буух суух хөдөлгөөнийг ЦАХ-аар зай бариулчхаад автобус, машиндаа ороод хажуудаа нийлээд наалдаад сууж байгаа шүү дээ. Ямар учиртайг ойлгохгүй байна
 - Ойлгомжгүй
 - Хатуу хөл хорио бүрэн утгаар хэрэгжихгүй байна. Хий дэмий эрүүл мэндээрээ хохирч байна
 - шийдвэр ойлгомжгүй
 - автобусны буудлаар маш олон цагаар зогсох нь ямар ч үр дүнгүй асуудал болж байна, гэр хорооллын иргэд болон худаг зэргээр маш их хөдөлгөөн үүсэж байна, мөн төв зам руугаа чиглэхээс илүү гэр хороолол руу явган эргүүлийг чиглүүлмээр байна
 - 1 тээврийн хэрэгслээр сайн хангах
 - Автобусны буудал дээр иргэдийн хоорондох зайг бариулдаг болооч нийтийн тээврийн автобус нь дотроо хүн дүүрсэн, хүн хоорондох зай алдагдсан эрсдэл өндөр байдаг, нийтийн автобусанд цагдаагийн албан хаагч хяналт тавих боломжгүй үүнээс болж иргэн, цагдаа хоёрын хооронд зөрчил үүсдэг
 - 119 тоот дугаараас иргэдэд өгсөн зарим заавар зөвлөгөө төөрөгдүүлж байна. Жишээ нь: шинжилгээний хариу гэх мэт
 - Дарга бүр өөр өөрийн тушаал шийдвэр гаргадаг. Энэ нь өөр хоорондоо зохицохгүй, ямар ч уялдаа холбоогүй байна
 - Хамгаалалтын зардал
 - Хүндрэл байхгүй
 - Хэт их цуглуулахгүй, цахимаар үүрэг чиглэл өгмөөр байна
 - Иргэд хөл хорионы дэглэм сахихгүй, ухамсаргүй байна


- Засгийн газрын шийдвэр, УОК шийдвэр ойлгомжгүй, нэг талдаа биш байна
- Тусгаарлалт
- Ер нь ойлгомжтой
- Гарсан шийдвэрүүд нь эргэж буцсан, шийдвэрүүд ойр ойрхон гарч байгаа нь
- Хатуу хөл хориог бүрэн утгаар нь хэрэгжүүлбэл үр дүнтэй
- Дуудлага өгсөн иргэд гэртээ оруулахгүй байна
- Одоо санал хүсэлт алга байна аа
- Баруун эргүүл
- Авто машиныг хэвийн явуулах
- Ажлыг тэгш хуваарилах
- Хөрсөн дээрээ буугаагүй тушаал шийдвэр!!!
- Байхгүй
- Ойлгож мөрдөж ажиллаж байна
- иргэд маань дэглэм журмыг сайн дагаж мөрдөөд байвал бэрхшээлтэй зүйл алга байна
- оновчтой шийдвэр гаргахгүй байна
- өгсөн үүргийн дагуу ажиллаж байхад дахин нэг дарга нь ирж өөр юм ярьж загнадаг.
- Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай
- 2 цаг тутам амарч дулаацах тодорхой цагтай болгох хэрэгтэй
- Орон тоо хүрэлцээ муу
- 800 мянгаа авмаар байна даа
- Онц шаардлагагүй газар эргүүлд гаргах
- Цагдаагийн алба хаагчийг эсэргүүцэх
- Алба хаагчдад үүрэг гүйцэтгэхэд ойлгомжгүй асуудал одоогоор гараагүй байна.
- Иргэд хорио цээр гэдгийг ухамсарлахгүй байгаагийнх
- Гадуур иргэд их сэлгүүцэж хаашаа ямар ажилтай явааг нь асуухаар дэлгүүр, эмийн сан гэж худлаа хэлж гадуур явж байна
- Иргэд гудамжинд ихээр гарч ирж байна. Шаардлага тавихаар эсэргүүцэж байна.
- Дээрээс өгсөн үүрэг чиглэлийг хэлтэс, тасгийн дарга нар хэрэгжүүлэхдээ хэтэрхий сүржин байна
- Үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байна
- Ойлгомжтой байна гэж
- Өгсөн үүрэг ойлгомжтой байгаа
- Шалтгаангүй хөдөлгөөн
- гадаа орчны цаг агаар хүйтэн байгаа болохоор бэрхшээлтэй байна
- Иргэд ойлголт муу байна
- Яг одоогоор бидний шаардлага ямар ч үр дүнгүй байна
- Автомашины зөвшөөрлөө багасгах, шаардлагатай байгууллагаас 1 тээврийн хэрэгсэл, алба хаагчдаа ай.магт зөвшөөрлөх шаардлагатай байна
- дээд удирдлагыг шийдвэр будилаантай байна гэх мэт хариултыг өгсөн байна.

Асуулт 11. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулан ажиллахад иргэдээс ирж буй хандлага, нөлөөлж буй байдал? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнээс 30,8 хувь нь Засгийн газар, Онцгой комиссоос гаргасан шийдвэр иргэдийн амьдралын зайлшгүй хэрэгцээг зохицуулж чадахгүй байгаа бөгөөд үүнээс улбаалан 40,8 хувь нь алба хаагчаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй, харьцаа хандлага тааруухан байна гэж үзжээ.

Хүснэгт №5. Үүрэг гүйцэтгэлд иргэдийн хандлага нөлөөлж буй байдал

	Frequency	Percent
Иргэдийн харьцаа хандлага тааруу байна, тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байна	434	40,8
Иргэдийн харьцаа хандлага сайн, тавьсан шаардлагыг биелүүлж байна	254	23,8
Valid Засгийн газар, онцгой комиссоос гаргасан шийдвэр нь амьдралын зайлшгүй хэрэгцээ, хувь хүний хүндэтгэн үзэх тохиолдлыг зохицуулж чадахгүй хүндрэл учруулж байна	328	30,8
Өөр бусад: Иргэд бэлэн байдлыг ойлгоогүй, ухамсар дорой байна, сул чөлөөтэй сэлгүүцэх гэж оролдох мөн зарим ААН хэвийн горимд шилжүүлснээс хөл хөдөлгөөн ихэссэн г.м.	49	4,6
Total	1065	100,0

Диаграм №13. Үүрэг гүйцэтгэлд иргэдийн хандлага нөлөөлж буй байдал



Асуулт 12. Иргэд ямар төрлийн зөрчил ихээр гаргаж байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 96,2 хувь буюу 1025 алба хаагч хариулт өгсөн. Үүнээс 63,6 хувь нь иргэд Засгийн газар, онцгой комиссоос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхгүй байна гэж үзжээ.

Хүснэгт №6. Иргэдээс гаргаж буй зөрчлийн төрөл

	Frequency	Percent
Valid	Алба хаагчаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй, эсэргүүцэж байна	354 34,5
	Засгийн газар, онцгой комиссоос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхгүй байна	652 63,6
	Цагдаагийн алба хаагчийн биед халдаж байна	19 1,9
Total	1025	100,0

Диаграм №14. Иргэдээс гаргаж буй зөрчлийн төрөл



Асуулт 13. Иргэд ЦАХ-ийн тавьсан шаардлагыг ямар хэлбэрээр эсэргүүцэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 96,4 хувь буюу 1027 алба хаагч хариулт өгсөн. Үүнээс 64,5 хувь нь иргэд хэл амаар доромжлон алба хаагчаас тавьсан шаардлагыг эсэргүүцэх хэлбэрийг дийлэнхдээ гаргадаг гэж хариулжээ.

Хүснэгт №6. Иргэдээс алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх хэлбэр

	Frequency	Percent	
Valid	Хэл амаар доромжлох	662	64,5
	Биед хүч хэрэглэн халдах	2	0,2
	Тээврийн хэрэгслээр дайрах	17	1,7
	Дарга, удирдлагаар яриулах	34	3,3
	Үгүй	16	1,5
	Бусад:	296	28,8
Total	1027	100,0	

Диаграм №15. Иргэдээс алба хаагчийн тавьсан шаардлагад хандаж буй байдал



Асуулт 14. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулан ажиллах үед Цагдаагийн албаны тухай хуульд заасан эрх хэмжээг хэрэгжүүлэн ажиллах боломжтой байгаа эсэх (хүний бичиг баримт шалгах, иргэнд шаардлага тавих, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, согтуурсан, мансуурсан байдлыг шалгах г.м) гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Тийм гэж 319 алба хаагч буюу 30 хувь, Үгүй гэж 78 алба хаагч буюу 7,3 хувь, Халдвар авах эрсдэлтэй байна гэж 668 алба хаагч буюу 62,7 хувь тус тус хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 62,7 хувь нь үүрэг гүйцэтгэх аюулгүй байдлын

баталгаа бага буюу халдвар авах эрсдэл бүхий гэж тодорхойлсон байна.

Диаграм №16. ЦАТХ-д заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх боломж



Асуулт 15. Халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл (маск, бээлий, ариутгалын бодис г.м)-ийн хэрэгцээ шаардлага хангаж байна уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Хангалттай хүрэлцээтэй гэж 413 алба хаагч буюу 38,8 хувь, Хүрэлцээгүй байна гэж 306 алба хаагч буюу 28,7 хувь хариулсан ба цаашид хангалтай олгох шаардлагатай байна гэж 346 алба хаагч буюу 32,5 хувь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 71,3 хувь нь халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл дутагдалтай байгаа ба хүрэлцээтэй хэмжээгээр олгох шаардлагатай гэж үзжээ.

Диаграм №17. Алба хаагчийн аюулгүй байдал хангасан эсэх



Асуулт 17. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулан ажиллах үеийн цалин хангамж, нэмэгдэл, урамшуулал олгогдож байгаа юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчид 100 хувь буюу 1065 алба хаагч хариулт өгсөн. Үүнд, Урамшуулал олгогдож байгаа гэж 111 алба хаагч буюу 10,4 хувь, Урамшуулал олгогдохгүй байна гэж 330 алба хаагч буюу 31 хувь хариулсан ба цаашид алба хаагчид урамшуулал олгох нь зөв гэж 624 алба хаагч буюу 58,6 хувь нь хариулжээ. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 89,36 хувь нь урамшуулал олгохгүй байгаа ба урамшуулал олгох шаардлагатай гэж үзжээ.

Диаграм №18. Цалин хангамж, нэмэгдэл, урамшуулал олголт



Асуулт 18. Үүрэг гүйцэтгэж байх хугацаанд иргэд ямар санал хүсэлтийг их гаргаж байгаа эсэх цаашид шийдвэрлүүлэх асуудлын талаарх санал? гэсэн нээлтэй асуултад 444 алба хаагч ямар нэгэн бэрхшээл байхгүй болохыг илэрхийлсэн бол 58,3 хувь нь дараах байдлаар санал хүсэлтийг илэрхийлсэн байна. Түүврийг тоймловол:

- Үүрэг гүйцэтгэх хугацаанд алба хаагч нарыг өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар санал их гарч байна.
- Хувийн тээврийн хэрэгслээр зорчих
- Ялгаваргүй бүх нийтийн хөдөлгөөнийг хязгаарлах
- Цалин нэмэх
- Аймгийн онцгой комиссын шийдвэрцүд зарим иргэдийн өрхийн амьжиргаанд нийцэхгүй байгаа
- Хөл хорионд орсон иргэдийг хэзээ орон нутагт явуулах шинжилгээ өгөх хуваарийг олон нийтэд мэдээлэх саналыг гаргаж байна.
- Хорио цээрийн дэглэм буулгахгүй орон нутгийн замаа нээх
- Хөл хориог сунгах
- Идэш, хүнс авах хөдөлгөөнд оролцох
- Сумын төвд амьдардаг боловч мал бүхий иргэд өдөр бүр малдаа явах шаардлагатай байна гэх
- Гаднаас ирж байгаа иргэдийг сайн тусгаарлах талаар
- Хамгаалах хэрэгслээр хангах
- Хөл хорио хэзээ тавих вэ? Ажлаа хиймээр байна санал хүсэлт хэлж байна
- Зөвшөөрлийн бичиг авахад хүндрэлтэй байна
- Цагийн хязгаарлалтыг өөрчлөх
- ЗГ, УОК-оос гаргасан шийдвэрийг хүлээн авахгүй байна
- ЗГ-ын шийдвэр хөрсөнд буудаггүй
- Ойлгомжгүй зүйл их асууна
- Хоол ундгүй байна. Ажил төрөлдөө ормоор байна гэх иргэд их байна.
- Хэзээ хорио тавигдах вэ
- Согтууруулах ундаа худалдаалагдаж байгаа талаар гомдол гаргаж байгаа
- Хорио цээрийн дэглэмийг өвчин намдтал сахиулж, гэрээр шаардлагатай хүнс барааг хүргэлтээр зохион байгуулах
- Явъя гэх хүсэлт их тавидаг
- Хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулахыг
- Гэртээ оруулах сонирхолгүй байна.
- Хорио цуцлах
- Ажилдаа явмаар байна
- Хорионы дэглэмийг цуцлаад, хувийн ариун цэврийг сайтар хангах санал хүсэлтэй иргэд их байна даа
- Хамгаалж чадахгүй ээ
- Гарч байгаа шийдвэрцүд ойлгомжгүй байна, тодорхой мэдээлэл хэрэгтэй байна

- *Хариу хэзээ гарах уу, хаанаас асуух уу, хөдөө явахад яах уу, хариу ирэхгүй байна, 119 ажиллахгүй байна, шинжилгээ удаан авах эрхтэй*
- *болгоомжтой байхыг захидаг*
- *Төрийн албан хаагчийн харьцааны талаар*
- *Онцгой комиссоос гаргасан шийдвэр нь шууд биш, иргэдэд мэдээлэл бүрэн гүйцэд хүрсний дараа буюу 1-2 хоногийн дараагаас хэрэгждэг баймаар байна. (Зарим тохиолдолд)*
- *Дэглэмийг хэрэгжүүлэхгүй эсэргүүцэх байдал их байна, ахуй амьдралд чиглэсэн шийдвэрийг засгийн газар гаргах хэрэгтэй гэж үзэж байна*
- *Өвчин хорионы үед дуудлаа, байнга утсаар залгалаа, гэх мэтээр гомдоллож байна*
- *хувийн тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох*
- *Цар тахлын талаар иргэдэд сурталчилгаа хууль тогтоомж шийдвэрийг мэдсэн мөртөө зөрчиж байна үүнийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд танилцуулах*
- *хяналтыг зохих журмын дагуу сахиж байхад бид энэхүү өвчнийг даван туулж чадна гэж бодож байна*
- *Автобус явж байхад бид явна шүү дээ, ойлгомжгүй тогтоол, захирамж гаргахаа боль гэх мэт*
- *Хүнс авах*
- *хөл хорио гэдэг зүйл их ядаргаатай байна, амьдрал хэцүү байна гэх мэт*
- *Иргэд бухимдалтай байна, зорчих эсэх талаар*
- *Иргэдийн амьдралд нийцэхгүй хууль, тогтоомж, шийдвэр гаргаж байна гэх*
- *Хөл хориог сулруулах*
- *хорио хэзээ тавигдах вэ*
- *УОК, Нийслэлийн ОК, Дүцүргийн ОК-ийн шийдвэр ойлгомжтой, нэг цаг хугацаанд, адил тэвшинд гардаг байхыг шаардаж байна.*
- *Хөл хориог зүгээр л үзэмж төдий байна, бодитой юм алга гэх*
- *Хөл хориог цуцлах*
- *Иргэдэд Онцгой комиссоос гаргаж байгаа мэдээ мэдээлэл, цаг тухай бүр хүрэхгүй байна.*
- *Хүсэлтийг биелүүлэх боломж бага*
- *хөл хорио хэзээ тавигдах вэ?*
- *хорио үзэрийг дотооддоо тавьж өгмөөр байна гэх мэт хариу尔тыг өгсөн байна.*

САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Санал асуулгад 8 нэгжийн 1065 алба хаагч буюу нийт бүрэлдэхүүн хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт 1065 алба хаагчаас 926 алба хаагч буюу 86,9 хувь нь эрэгтэй алба хаагч, 139 алба хаагч буюу 13,1 хувь нь эмэгтэй алба хаагч байх ба эрэгтэй алба хаагч 6 дахин илүү хамралттай байгаа нь хүн амын хүйсийн харьцааны хувьд харьцангуй ялгаатай боловч албаны онцлогийн хувьд нийцтэй байна. Ажилласан жилийн хувьд 11-15 жил ажилласан алба хаагчид дийлэнх хувийг эзэлжээ. Албан тушаалын ангиллын хувьд нийт 1065 алба хаагчийн 99,4 хувь нь хариулт өгсөн ба 512 алба хаагч буюу 48,3 хувь нь офицер, 547 алба хаагч буюу 51,7 хувь нь ахлагч бүрэлдэхүүн хамрагдсан болохыг тодотгон сонголт хийжээ. Цолны хувьд харьцангуй ижил түвшинд буюу 48,3х51,7 хувь офицер, ахлагч бүрэлдэхүүн оролцсон байна.

Судалгааны тоон үзүүлэлтээс харвал алба хаагчдын 71,1 хувь буюу (3 хүн тутмын 2) нь 12-оос дээш цагаар ажиллаж, 64,5 хувь нь 8-10 цагаар амарч байна. Үүнээс алба хаагчид нийтлэг байдлаар 54,1 хувь нь (2 хүн тутмын 1 нь) гэр бүлдээ цаг зарцуулж чаддаггүй байна.

Мөн алба хаагчид нийтлэг байдлаар 98,4 хувь нь Коронавируст халдварт өвчний талаарх ойлголттой, 98,9 хувь нь бүх нийтийн бэлэн байдлын үед цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн хэрэгжүүлэх чиг үүргийг ойлгож, мэдсэн, 82,5 хувь нь Улсын их хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд шууд удирдлагаас өгсөн шийдвэрийг хэрэгжүүлж байна гэж тодорхойлсон байна. Үүнээс 50 хувь нь дээрх нэн шаардлагатай мэдээ мэдээллийг байгууллага, удирдлагаас авч байгаагаар илэрхийлжээ. Түүнээс 52,9 хувь нь цахим хуудсаар буюу өөрсдийн дотоодын фейсбүүк группээс танилцаж байгааг илэрхийлжээ.

Алба хаагчдын 80,9 хувь нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэл /аймаг/-ийн онцгой комиссоос гаргаж буй шийдвэр нь ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байна

гэж үзжээ. Нийтлэг байдлаар 95,5 хувь нь удирдлагын шийдвэр, өгсөн үүрэг, ажлын чиглэлийг ойлгомжтой гэж үзсэн бөгөөд 40,8 хувь нь иргэд алба хаагчаас тавьсан шаардлагыг биелүүлэхгүй, харьцаа хандлага тааруухан байна гэж үзжээ.

63,6 хувь нь иргэд Засгийн газар, онцгой комиссоос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхгүй байна гэж үзжээ. Тэдгээрээс 64,5 хувь нь иргэд хэл амаар доромжлон алба хаагчаас тавьсан шаардлагыг эсэргүүцэх хэлбэрийг дийлэнхдээ гаргадаг гэж хариулжээ.

Алба хаагчдын 62,7 хувь нь нь үүрэг гүйцэтгэх аюулгүй байдлын баталгаа бага буюу халдвар авах эрсдэл бүхий гэж тодорхойлсон бол 71,3 хувь нь халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл дутагдалтай байгаа ба хүрэлцээтэй хэмжээгээр олгох шаардлагатай, 89,3 хувь нь урамшуулал олгохгүй байгаа ба урамшуулал олгох шаардлагатай гэж үзжээ.

Алба хаагчдаас хамгийн олон дэвшүүлсэн саналыг эрэмбэлбэл:

- Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэр нэг мөр, тэнцвэртэй байх.
- Удирдлагаас өгөх үүрэг даалгаврын давхцалыг арилгаж, эргүүлийн цагийг чанартай богино байлгах.
- Алба хаагчдын аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авах, халдвар хамгаалал, хувцас хэрэгслээр хангах гэсэн дараалалтай байна.